

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ 95 ЖИЛД: ОЛОЛТ, СОРИЛТ, СУРГАМЖ

Доожавын Ган-Очир¹

<i>JEL ангилал:</i>	<i>Хураангуй:</i>
A10, E02, G21, J24	Энэ онд Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ой тохиож байна. Энэхүү судалгааны өгүүлэлд Монголын эдийн засаг, банкны салбарт 95 жилийн хугацаанд тулгарсан сорилт, гарсан ололт, амжилтыг нэгтгэн баримтжуулж, түүхэн сургамж, цаашид анхаарах асуудлыг тоймлон танилцуулахыг зорилоо.
<i>Түлхүүр үг:</i>	
Банкны салбар, мөнгөн тэмдэгт	

1. Удиртгал

Монгол Улс мөнгөн гүйлгээний талаар өнө эртний түүхтэй билээ. Манай эриний III зууны сүүлчээр байгуулагдсан Хүннү гүрний үеэс зоосон мөнгө хэрэглэж ирсэн бол Чингис хаан Монголын тулгар төрийг эмхлэн байгуулаад зоос цутгуулан хэрэглэж, 1227 онд цаасан мөнгө хэвлэн гүйлгээнд гаргаж байсан баримт бий. Чингис хааны үе залгамжлагчид Монголын нэгдсэн гүрний үед 100 гаруй төрлийн алт, мөнгө, зэс, гууль, хүрэл зоос цутгуулж, цаасан мөнгийг дахин хэвлүүлж гүйлгээнд гарган таваарын гүйлгээнд хэрэглэж, эд баялгаа тооцоолон гадаад гүрнүүдтэй худалдаа наймаа эрхэлж байсан ажээ [24].

Энэхүү баялаг уламжлал нь эзэнт гүрний задрал, Манж Чин улсын нөлөөнд явж ирсэн он жилүүдэд уусан арилсан хэдий ч 1921 оны Ардын хувьсгалын дараа үндэсний банк байгуулагдаж, орчин цагийн Монголын санхүүгийн тогтолцооны суурь тавигдсан билээ. Монгол Улсын Засгийн газрын 1922 оны гуравдугаар сарын 27-28-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банк (Монголбанк) 1924 оны зургаадугаар сарын 2-ны өдөр анх байгуулагдсан ажээ. Энэ цагаас хойш сорилт, ололт амжилтаар дүүрэн он жилүүд өнгөрсөөр өнөөдрийг хүрсэн бөгөөд бидэнд түүхийн хуудсаас авах сургамж, цаашид эдийн засгийн бодлогын түвшинд анхаарах асуудал цөөнгүй байна.

¹ Эдийн засгийн ухааны доктор, Монголбанкны Ерөнхий эдийн засагч.

Цахим шуудан: doojav_ganochir@mongolbank.mn

Тус өгүүлэл дэх статистик мэдээллийг бэлтгэхэд тусалсан Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч Г.Мөнхбаярт талархал илэрхийлье.

Иймд энэхүү судалгааны өгүүлэлд Монголын эдийн засаг, банкны салбарын 95 жилийн түүхэн үйл явдлыг тоймлож, сорилт, ололт амжилтыг нэгтгэн баримтжуулж, сургамж, цаашид анхаарах шаардлагатай бодлогын асуудлыг хөндөж гаргахыг зорилоо.

Өнгөрсөн 95 жилд банк, санхүүгийн салбар олон улсын түвшинд хүртэл хөгжиж, гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, улс орны бүтээн байгуулалт, нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирлээ. Монголбанк нь байгуулагдсан цагаас эхлэн банк, санхүүгийн системийг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтийг хангах, эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтийг олон улсын стандартад нийцүүлэн гаргах, гадаад валютын улсын нөөцийг удирдах, төлбөр тооцооны системийг хөгжүүлэх зэрэг олон чиглэлээр улс орны хөгжилд эерэг өөрчлөлтүүдийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэлээ.

Үндэсний банк байгуулагдаж, үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг гүйлгээнд гаргасан явдал бол Л.Түдэв гуайн хэлснээр “буун дуугүй хувьсгал”, тусгаар тогтнолын баталгаа байв. Монголбанк 1924-1991 онд санхүүгийн зуучлал, санхүүгийн системийн хөгжлийг дангаар тодорхойлж, санхүүгийн зах зээл дээрх монополь тоглогч байсан бол 1991 оноос хойш банкны хоёр шатлалт тогтолцоо үүсэж, эрчимтэй хөгжөөд байна. Эдүгээ банкны салбарын нийт актив нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээг давж, харилцах, хадгаламж нь ДНБ-ий 60 орчим хувь, нийт зээлийн үлдэгдэл нь ДНБ-ий 50 гаруй хувь болж санхүүгийн зуучлал гүнзгийрээд байна. Банкны салбар 1500 орчим салбар, нэгж, 16 мянга гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, эдийн засгийн томоохон салбар болж өргөжөөд байна. Төлбөр тооцооны орчин үеийн санхүүгийн технологиуд өргөнөөр нэвтэрч санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байна. 2018 оны эцсийн байдлаар банкны салбарт 4.6 сая харилцах данс, 3.2 сая хадгаламжийн данс, 1.2 сая зээлийн данс байгааг хүн амын тоонд харьцуулж үзвэл, Монгол Улсын нэг иргэн банкинд 1.4 харилцах данстай, нэг хадгаламжийн данстай, 3 хүн тутмын нэг нь зээлийн данстай гэсэн үзүүлэлт гарч байна. Банкнудаас гаргасан картын тоо 2018 оны эцсийн байдлаар 4.3 сая, үүнээс идэвхтэй ашиглаж буй карт 1.6 саяд хүрчээ. Банкны салбарын харилцагчид 2018 онд нийт 305.6 сая удаагийн гүйлгээгээр 30.6 их наяд төгрөгийн гүйлгээг хийсэн байна. Үүнээс пос машинаар 199.6 сая удаа 5.4 их наяд төгрөгийн, АТМ-ээр 101.3 сая удаа 24.7 их наяд төгрөгийн гүйлгээ тус тус хийгджээ. Техник, технологийн хөгжилтэй холбоотойгоор интернет болон мобайл банк ашигладаг харилцагчдын тоо нэмэгдэж байна. Тухайлбал, улсын хэмжээнд гурван хүн тутмын хоёр нь мобайл банкны идэвхтэй хэрэглэгч байгаа бол гурван хүн тутмын нэг нь интернет банкийг идэвхтэй ашиглаж байна. 2018 онд мобайл банкаар 3.4 их наяд төгрөгийн, интернет банкаар 4.6 их наяд төгрөгийн гүйлгээ тус тус хийгджээ.

Энэхүү судалгааны өгүүллийн хоёрдугаар хэсэгт, үндэсний банк байгуулагдахаас өмнөх үе буюу Хүннү гүрнээс Богд хаант Монгол Улс хүртэлх гүйлгээний хэрэгслийг тоймлон авч үзэхийн зэрэгцээ үндэсний банк байгуулагдах үеийн түүхэн нөхцөл байдлыг авч үзэв. Гуравдугаар хэсэгт, үндэсний банк (Монголбанк)-ны үйл ажиллагаа, мөнгө, санхүүгийн тогтолцоо 1924-1991 онд ямар сорилтуудтай нүүр тулж, хэрхэн хөгжиж ирснийг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзлээ. Ингэхдээ Худалдаа, үйлдвэрийн банк (1924-1954 он), БНМАУ-ын банк (1954-1991 он) гэсэн хоёр үед хуваан судалсан болно. Дөрөвдүгээр хэсэгт, хоёр шатлалт банкны тогтолцооны үүсэл, хөгжлийн үеийг банкны салбар, макро эдийн засаг, мөнгөний бодлогод гарсан үйл явдлын хувьд тоймлон авч үзэхдээ эдийн засгийн шилжилтийн үе (1991-2000 он), эдийн засгийн шилжилтийн дараах үе (2001 оноос эдүгээ хүртэл) гэж хувааж үзлээ. Сүүлийн хэсэгт, түүхэн сургамж, түүнд үндэслэн цаашид бодлогын хувьд анхаарах асуудлыг нэгтгэн тоймлолоо.

2. Монголд үндэсний банк байгуулагдахаас өмнөх болон байгуулагдах үеийн түүхэн нөхцөл байдал

2.1 Үндэсний банк байгуулагдахаас өмнөх үе

Монголын эзэнт гүрнийг байгуулж, хоёрдугаар мянганы хөгжлийг тодорхойлж, өрнө-дорно дахины хооронд арилжаа, харилцааны эхлэлийг тавьсан Монголчууд алт, мөнгөн зоос, цаасан мөнгөн тэмдэгтийг эдийн засгийн эргэлтэд эртнээс оруулж ирсэн түүхтэй билээ. Хэдийгээр зоос, мөнгөн тэмдэгтийн үүсэл дорно дахинаас эхтэй боловч Монголчуудын зоос, цаасан мөнгөн дэвсгэрт мөнгөний түүхэн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байв. Төв Азийн нүүдэлчдийн байгуулсан анхны хүчирхэг эзэнт гүрэн Хүннүгийн үед зэс зоос ашиглан худалдаа, арилжаа хийж байсан баримтууд олддог байна. Чингис хаан Монголын нэгдсэн тулгар төрийг үүсгэн байгуулж алтан зоос, харин Цагаадайн хаант улсын үед мөнгөн зоос цутгуулж, хэрэглэж байсан баримт бий. Чингис хааны үе залгамжлагчид Монголын нэгдсэн гүрний үед 100 гаруй төрлийн алт, мөнгө, зэс, гууль, хүрэл зоос цутгуулж², 1236 онд Өгөөдэй хаан, 1254 онд Мөнх хаан нар цаасан мөнгийг дахин хэвлүүлж байжээ [23].

Эзэнт гүрний уналтын дараа буюу Монгол Улс 1636-1911 онд Манж Чин улсын нөлөөнд явж ирсэн он жилүүдэд үндэсний мөнгөн тэмдэгтгүй байжээ. Үндэсний мөнгө, зээлийн систем байгаагүй тул үндэсний мөнгөний ч нэгж байсангүй. Тухайн үед мал, арьс шир, хадаг, цай зэрэг таваар, XIX, XX зууны зааг үед жингийн мөнгө, мөнгөн эмбүү, ангийн үс, хадаг, цай, их сангийн тийз, Орос, Хятадын зоос, мөнгөн тэмдэгт, Англи, Америк, Мексикийн мөнгөн тэмдэгт зэргийг арилжаанд ашиглаж, мөнгөний гүйлгээ эмх замбараагүй байжээ.³ 1900 онд Монголд Орос-Хятадын банкны салбар, 1907 онд Дайчин улсын банкны

² Монголын Юань улсын үед зоосноос гадна 40-өөд нэр төрлийн цаасан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргаж байсан мэдээ бий. Монголын Илхаант улс маш олон цуврал зоос гаргаж байсан нь зоосны түүхэнд хамгийн өргөн хүрээтэй, олон төрөлд тооцогддог байна (Монголбанк түүхийн альманах 2018).

³ Монголд 1860-1870 онд орон нутгийн чанартай цаасан мөнгөн дэвсгэрт хэрэглэж байжээ.

салбар байгуулагдаж байсан бөгөөд үндэсний банк (Монголбанк) байгуулагдах хүртэл Хаант Оросын банкны салбар хоёр удаа, Хятадын банкны салбар гурван удаа байгуулагдан ажиллаж, энэ хугацаанд Хятадын банкнаас Монголд паяз нэртэй цаасан мөнгийг гурван ч удаа гаргажээ. Тухайн үед таваар мөнгөний харилцаа хөгжөөгүй байсан тул Монгол орны нөхцөлд дээрх банкнууд цөөн жил ажиллаад хаагдсан ажээ [25].

Богд хаант Монгол Улсын үеэс өөрийн үндэсний банк байгуулах хэрэгцээ, шаардлага байгааг сайтар ойлгож, энэ талаар тодорхой алхмыг хийж байлаа. Манж Чин улсын ноёрхлыг эцэс болгон 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ололтыг баталгаажуулан Монгол Улс тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, Богд Жавзандамба хутагтыг хаан ширээнд залж, таван яам бүхий Засгийн газрыг байгуулжээ. Богд хааны Засгийн газрын дотоод, гадаад, сангийн гурван яам санал нэгдэж, Монгол Улсын албан зоос, цаас үйлдэх сан байгуулахаар тогтон, улмаар Их Орос улсын сайдтай 1912 онд гэрээ байгуулжээ. Богдын хүрээ нь 1911-1924 онд Хятад, Орос, Англи, Америк, Герман, Япон зэрэг орны пүүс, компаниудын үйл ажиллагааны төв, олон улсын худалдаа, зээлийн зах зээл болж байлаа. 1907 онд Хятадын банкны салбарыг Хүрээ болон Улиастайд нээсэн боловч банкны өр, төлбөрийн эргэн төлөлт хангалтгүй байснаас 1912 оны эцэст үүдээ хаажээ. 1912 онд Оросын харьяат Юферов гэгч Англи, Францын санхүүгийн пүүстэй хөрөнгө хувь нийлүүлсэн банк байгуулах санал тавьж, Монголын Засгийн газраас зөвшөөрөл авчээ. 1913 онд хаант Оросын Засгийн газар Юферовоос банк байгуулах эрхийг нь худалдан авч Монголд банк байгуулахаар төлөвлөж байгаагаа мэдэгджээ. Монголын тал үүнд татгалзах зүйлгүй, харин сангийн албаны тэмдэгт цаас, зоос (мөнгөн дэвсгэрт) үйлдэх эрхийг бусдад олгохгүй гэдгээ хариу мэдэгдэж байжээ. Улмаар банк байгуулах эрх Оросын “Сибирская торговля” банкинд худалдагджээ. 1914 онд Оросын Засгийн газар Монгол дахь худалдаа, санхүү, эдийн засгийн нөлөөгөө бататгах үүднээс банк байгуулах шийдвэр гаргажээ. Ийнхүү худалдааг санхүүжүүлэх, Монголын албаны байгууллагуудад мөнгө зээлдүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгт хэвлэх, Монголын зам харилцааг төвхнүүлэх зорилгоор 1915 онд Оросын эзэнт гүрний өмчлөл бүхий “Монголын үндэсний банк” нэртэй банкныг нээсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна. 1915 оны Монгол, Оросын хэлэлцээрийн дагуу Монголын үндэсний банк нэрээр мөнгөн тэмдэгт гаргахаар шийдэж, 1916 оноос гүйлгээнд гаргахаар бэлтгэж байсан ч зарим нэг шалтгааны улмаас хойшлуулж, Орост хувьсгал гарснаар гүйлгээнд гаргалгүй орхигджээ [2].

1917 онд Орост хувьсгал гарч, большевикууд засгийн эрхэнд гарснаар рублийн ханш унаж, Монголын эдийн засгийн байдал ч эрс хүндэрчээ. Энэ үед Нийслэл хүрээн дэх хятад сайд Хятадын Засгийн газраас нэг сая юанийн зээл авч, Оросын өрийг дарах, оронд нь Нийслэл хүрээнд Хятадын банкны салбар байгуулах саналыг Монголын талд тавьж, улмаар Чин улсын үед Гадаад Монголын аймаг, шавьд олгосон өрийн бичигт нэг жилийн хүү тооцохгүй байх санал дэвшүүлжээ. Энэ саналыг Монголын тал хүлээн авснаар 1918 онд

гэрээ байгуулж, Хятадын банкны салбарыг Хүрээнд нээсэн байна. Гэрээнд Монголын Засгийн газар, өөрийн харъяа газарт юанийг мөнгөн тэмдэгт болгох, Хятадын банкнаас гаргасан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд хэрэглэх, банк нь өөрийн мөнгөн тэмдэгтээр Монголын Засгийн газрын гаргасан мөнгөн тэмдэгт, бусад мөнгөн тэмдэгтийг солих, Монголын тал өөр мөнгөн тэмдэгт хэрэглэх тохиолдолд Хятадын Засгийн газраас зөвшөөрөл авах, Монголын Засгийн газар мөнгөө тус банкинд сарын гурван хувийн хүүтэйгээр хугацаагүй хадгалуулахаар заажээ. Энэ гэрээг байгуулснаар Хятадын банк Монголын мөнгөн тэмдэгт, төсөв, санхүүг мэдэх болж, рублийг албан ёсоор халж, Монголын Дундад Иргэн улсаас улам бүр хараат болох нөхцөлийг бүрдүүлж байв. 1919 онд Хятадын генерал Сюй Шүжэн Нийслэл Хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан банкны салбарын үйл ажиллагааг зогсоож, Хятад, Японы хамтарсан Жибин жань (Хязгаарыг үржүүлэх банк) банкны салбарыг нээн ажиллуулах шийдвэр гаргасан боловч жил хүрэлгүй Барон Унгерн Хүрээг чөлөөлөх үед тус банк үүдээ хаажээ.

Барон Унгерны үед Богд хаант Монгол Улсын Засгийн газар 1921 оны дөрөвдүгээр сард зургаан сарын хугацаатай цаасан мөнгийг өөрийн баталгаагаар гүйлгээнд гаргажээ. Мөнгөн тэмдэгтийг малаар баталгаажуулж гаргасан бөгөөд “бага болзоот” хэмээн нэрлэж, 10, 25, 50, 100-тын долларын дэвсгэртээр модон бараар Монголд хэвлэсэн байна. Ардын Засгийн газар 1923 онд энэхүү мөнгөн тэмдэгтийг гүйлгээнээс гаргажээ. Ийнхүү гадаадын банк, эх үүсвэр байсан хэдий ч үндэсний мөнгөн тэмдэгт, мөнгө, зээлийн тогтолцоог хөгжүүлж чадахгүй явсаар 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалтай золгосон байна.

2.2 Үндэсний банк байгуулагдаж, мөнгөн тэмдэгт гаргасан нь


Монгол Улсад 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын дараа эдийн засаг, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд шинэчлэл, өөрчлөлтийн олон чухал үйл явц өрнөсний нэг нь банкны салбарын үүсэл тавигдсан явдал байв. Тухайн үед мөнгөний гүйлгээ эмх замбараагүй (*олон валютаар хийгддэг*) бөгөөд зээл олгох, төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагааг хариуцан явуулах байгууллага байхгүй байсан нь албан татвар, зээл, худалдаа бэлтгэлийн хоорондын уялдааг бодлогоор дэмжихэд хүндрэл учруулж байлаа [25].

Ардын засгийн газар нь эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлэх ажлаа улсын төсөв, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээс эхлэв. Эхний ээлжид Монгол Улсад гүйлгээнд хэрэглэгдэж байгаа олон төрлийн мөнгөн тэмдэгтийг хооронд нь жиших ханшийг тогтоов. Валютын жишиг ханш тогтоосон Засгийн газрын 1921 оны долдугаар сарын 18-ны өдрийн тогтоолын дагуу улсын орлого, зарлага, мөнгөн санхүү, гүйлгээний тооцоонд тус жишгийг ашиглахаар болжээ. Хувьсгал ялах үед Монгол Улсад үндэсний мөнгөн тэмдэгт байгаагүй учир олон бараа, таваар гүйлгээний хэрэгсэл болж байсан тул тэдгээрийн хоорондын ханшийг үнэлэх жишиг нэгж тогтоосон нь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг урьдчилан тогтоосонтой утга чанар дүйцэх чухал арга хэмжээ байв.

XX зууны анхны хүн амын тооллогыг Богд хаант улсын үед буюу 1918 онд анх явуулж, тус тооллогын дүнгээр Монголын нийт хүн ам 647.5 мянга гэж

гарчээ. Үүнээс хойших түүхэн 95 жилийн хугацаанд хүн амын тоо 4.9 дахин, нэг хүнд ногдох бодит үндэсний нийт орлого (ҮНО) 27.1 дахин өссөн байна (Зураг 1).

Зураг 1



Эх сурвалж: ҮСХ (2012), “Монгол Улс 100 жилд” эмхтгэл болон ҮСХ-ны мэдээлэлд суурилсан судлаачийн тооцоо. 1919 оны ҮНО-ыг 1919-1940 оны хоорондын нийгмийн нийт бүтээгдэхүүний өсөлттэй адил байхаар тооцсон. 2000-2017 оны ҮНО-ыг 1986 оны зэрэгцүүлэх үнээр тооцохдоо 2010 оны суурьтай ДНБ-ий дефляторыг ашиглалаа.

Хүн амын өсөлт 1918-1950 оны хооронд маш бага буюу дунджаар жилд 0.7 хувиар өсжээ. Тухайн үед нийт малын тоо 9.65 сая толгой байсан бөгөөд нэг хүнд дунджаар 14.9 толгой мал ногдож байв. 2018 оны байдлаар нэг хүнд ногдох толгой мал 20.5 гарч байна. Энэ нь тухайн үед хүн ам цөөн, амьжиргаа нь дорой байсныг илтгэж байна.

Ардын Засгийн газар улс орны тусгаар тогтнолыг гадаад улсуудад зарлан мэдэгдэж, тэдэнтэй холбоо харилцаа тогтоохыг нэн чухалд үзэж байв. 1921 оны аравдугаар сард Москвайтай харилцаа тогтоож, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, бүрэн эрхт төлөөлөгч солилцох, санхүүгийн тусламж дэмжлэг авах зорилгоор өөрийн төлөөлөгчдийг Зөвлөлт засгийн газартай хэлэлцээ хийлгэхээр илгээжээ. Улмаар 1921 оны арван нэгдүгээр сард “Монгол, Орос улсын хооронд найрамдлын барилдлага байгуулах тухай” гэрээ бичигт гарын үсэг зурав. Тус гэрээгээр хоёр этгээд бие биенийхээ Засгийн газрыг хууль ёсны болохыг хүлээн зөвшөөрч, бүрэн эрхт төлөөлөгч харилцан солилцохоор тогтжээ. Хэлэлцээрийн нэг чухал асуудал нь Монголын Засгийн газар Зөвлөлт Орос Улс (ЗОУ)-ын Засгийн газраас зээл авах явдал байв. Монголын тал санхүүгийн хувьд, ялангуяа бэлэн мөнгөөр гачигдаж байсан тул ЗОУ-д хандаж зээл олгохыг хүсжээ. Улмаар ЗОУ-ын Засгийн газраас Монголын Ардын Засгийн газраас хэвлэн гаргахаар зорьж буй 3.5 сая мөнгөн тэмдэгт цаасны баталгаа болох нэг сая рубль буюу түүнтэй дүйцэх цагаан мөнгө олгох (цагаан мөнгө өгөхдөө 1922 оны Орос улсын дотор худалдаалагдаж буй үнэ ханишийг баримтлан бодож олгоно), энэ мөнгийг Эрхүү мужийн сангийн хэлтэст Монголын Засгийн газрын нэр дээр хадгалуулж, үүний 1/4-ийг 1921 онд багтаан олгохоор тохиролцжээ. Зээлийн төлбөрийг Монголын тал мал аж ахуйн түүхий эдээр төлөхөөр тогтжээ. Улмаар

1921 оны арван нэгдүгээр сард “Монгол Улсын мөнгөн тэмдэгт хэвлүүлэх тухай гэрээ” байгуулжээ.

Ардын Засгийн газар 1922 оноос улсын банк байгуулахтай холбоотой асуудлыг удаа дараа хэлэлцэж, бэлтгэл ажлыг эхлэв. 1922 оны хоёрдугаар сард Түр цагийн хурлаар Сангийн яамны оруулж ирсэн “Улсын хоршоо сайжруулах банк нээх” тухай асуудлыг хэлэлцээд зүйтэй гэж үзжээ. Эдийн засгийг хөгжүүлэх чиглэлийг боловсруулах ажил 1922 оноос эхэлж, “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх баримт бичгийг Монгол Ардын Нам (МАН)-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, улмаар Засгийн газрын 1923 оны долдугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар баталжээ. Энэ баримт бичигт үндэсний банк байгуулах, мөнгөн тэмдэгт гаргах замаар Монголчуудын мөнгөний гачигдлыг арилгах, санхүү төсөв, данс бүртгэлийн тогтолцоо бий болгох асуудлыг тодорхой тусгаж байв. Тухайн үеийн улсын эдийн засгийн чадавх, мэргэжилтэй ажиллах хүчний хангамжаас шалтгаалан дан ганц өөрийн хүч, хөрөнгөөр банк байгуулах бололцоогүй байсан тул Монголын Засгийн газарт туслалцаа үзүүлэхийг Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-д хандан хүсэж байжээ.⁴ 1923 оны долдугаар сард Бүх Холбоотын Коммунист (большевик) Намын Төв Хорооны Улс төрийн товчооны хуралдаанаас *“Орос-Монголын банк яаралтай байгуулах нь чухал гэдгийг зөвшөөрч, уг банкны дүрмийн зохих төслийг долоо хоногийн дотор боловсруулан батлуулахаар оруулах, Оросын хувь нь 100'000 алтан рублиэс хэтрэхгүй байх, түүнийг төлөх хугацааг тодорхойлохыг Санхүүгийн хороонд даалгасугай”* хэмээн тогтоол гарч, Төв Хорооны нарийн бичгийн дарга И.Сталин гарын үсэг зурсан байна. Ийнхүү ЗХУ-ын дэмжлэг, оролцоотойгоор хувь нийлүүлсэн банк байгуулах шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар гаргаж, 1924 оны гуравдугаар сарын 17-ны өдөр Засгийн газрын хурлаас Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банкны дүрмийг баталжээ. Дүрэм ёсоор ЗХУ, Монголын хоорондын эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, Монголд худалдаа, аж үйлдвэр хөгжүүлэх, бас өөрийн ажиллагааны хүрээнд мөнгөний эргэлтийг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлж Монголын Засгийн газрын улсын төсвийн орлого, зарлага кассын тооцооны ажиллагааг хариуцах, мөн Засгийн газартай тусгай хэлэлцээр байгуулсны үндсэн дээр бусад үйл ажиллагааг гүйцэтгэх үүрэгтэй байв.

Монгол Улсын Засгийн газрын түүхэн шийдвэрийн дагуу хувь нийлүүлсэн “Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк” 1924 оны зургаадугаар сарын 2-ны өдөр Нийслэл хүрээнд нээгдсэн нь Монголбанкны суурь тавигдсан түүхт үйл явдал байв. Монголбанкны анхны салбарыг Алтанбулагт байгуулжээ. Тус банк 250'000 алтан рубль (*тухайн үеийн ханишаар 260'000 хятадын янчаан*)-ийн дүрмийн сантай, 22 орон тоотой, үүнээс 18 нь зөвлөлтийн мэргэжилтэн, 4 монгол ажилтантай байгуулагдаж байжээ. Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн банк байгуулахдаа “Худалдаа, аж үйлдвэрийн банк”, “Монголбанк” гэсэн нэрийг

⁴ 1921 оны Ардын хувьсгалын ялалтын үр дүнд Ардын эрхт хэмжээт цаазад Монгол улсыг тунхагласан. Үүнээс хойших 70 жилд Монгол Улс улс төр, эдийн засаг, худалдаа, цэрэг, геополитикийн бодлого дээр Зөвлөлт Холбоот Улсын тусламж дэмжлэгтэйгээр явж ирсэн билээ.

хэрэглэдэг байсан ч албан хэрэгт ихэвчлэн “Монголбанк” гэж нэрлэж байжээ [3]. Ийнхүү үндэсний банк (Монголбанк) байгуулагдсанаар Монголын мөнгөний тогтолцоо үүсэж бэхжих, үндэсний мөнгөн тэмдэгттэй болох эхлэл тавигдаж, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах суурь бүрдэв.


Тухайн үед Монголын үндэсний банк (Монголбанк)-ны үндсэн үүрэг нь үндэсний мөнгөн тэмдэгттэй болох, улс ардын аж ахуйн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, ард иргэдийн хувийн мөнгөн хадгаламжийг хадгалах, арвижуулах тэдний хооронд хийгдэх тооцоог дамжуулан хийх явдал байлаа. Монголбанк байгуулагдсан өдрөөс эхлэн албан газруудын нэр дээр данс нээж, тэдний хөрөнгийг төвлөрүүлэх, гуйвуулга тооцооны гүйлгээг хийх, аж ахуйн байгууллага, Монголд байсан Зөвлөлтийн байгууллага, гадаадын пүүс, энгийн иргэдэд зээл олгох зэрэг ажлыг гүйцэтгэж эхэлжээ [25].

1920-иод онд мөнгөний шинэчлэл хийж, Монголын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг гүйлгээнд гаргаж, худалдаа бэлтгэлийн ажиллагааг санхүүжүүлж, зах зээлийн барааны хангамж, үнийн хөдөлгөөнийг зохицуулж, ардын аж ахуйтанд зээл олгож байсан нь Монголбанкны үндсэн үйл ажиллагаа болж байлаа. Тухайлбал, БНМАУ-ын Их хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газраас 1925 оны хоёрдугаар сарын 22-нд мөнгөний шинэчлэл явуулах тухай тогтоол гаргаж, Монголын үндэсний мөнгөний нэгжийг “төгрөг” гэж нэрлэж, үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах эрхийг Монголбанкинд олгожээ. Иймд 1925 оны арванхоёрдугаар сарын 9-ны өдөр Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртээр гүйлгээнд гаргаж, мөнгөний эргэлтийн эмх замбараагүй байдал, олон төрлийн мөнгөний гүйлгээг зогсоож чадсан байна. Мөн тус онд Улсын мөнгөн тэмдэгт гаргах, түүнийг хуурамчаар үйлдэх тохиолдолд шалгах дүрмийг Засгийн газраас гаргаж байжээ. Үндэсний мөнгөн тэмдэгт гаргасан үйл явдалд ард түмэн талархалтай хандаж, *“Ардын Засгийн анхны мөнгөн эрдэнэ! Үүгээр л бид наймаа хийнэ”* хэмээж байжээ. Гүйлгээнд байсан төгрөг 1926-1927 онд 46 дахин өсөж, янчааныг дотоодын зах зээлээс шахан гаргаж, гүйлгээг дангаар хангахуйц тогтвортой байр суурийг эзэлжээ.

1924 оны эцэст банкны салбарын нийт актив 1.64 сая төгрөг, нийт зээл 19.5 мянган төгрөг байсан бол 1924-1930 онд актив болон зээлийн өсөлт харгалзан нэг жилд дунджаар 67 болон 214 хувиар өсөж, 35.1 сая төгрөг болон 18.5 сая төгрөгт хүрсэн байна (*Зураг 2*).

Зураг 2

Банкны салбарын зээл, активын дундаж өсөлт, 1924-2018



Эх сурвалж: ҮСХ (2012). “Монгол Улс 100 жилд” эмхтгэл болон ҮСХ-ны мэдээлэлд суурилсан судлаачийн тооцоо.

Үндэсний мөнгө, зээлийн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд үндэсний мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргахын зэрэгцээ түүний ханшийг тогтворжуулах, санхүү, зээл, төлбөрийн бүх тооцоог төгрөгийн нэгжид шилжүүлэн тооцож жигдрүүлэхэд анхаарч байв. Банкны тэмдэгтийг улсын бүх албан татвар, гааль болон бусад төлбөрт, мөн энгийн хүмүүсийн хооронд төлбөрт өгч авалцахад заавал хэрэглэнэ хэмээн дүрэмд зааж өгчээ. Түүнчлэн гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгтийн 25 хувь нь үнэт металл, зоос, гадаадын тогтвортой валютаар, харин 75 хувь нь түргэн борлогдох таваар болон богино хугацаат зээлийн векселиэр баталгаажсан байна. Эдгээр арга хэмжээ нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг итгэх итгэлийг нэмэгдүүлж, төгрөгийн ханш чангарахад ч нөлөөлж байв. Тухайлбал, үндэсний мөнгөн тэмдэгт гаргах үед 1 төгрөг янчааны 88 центтэй тэнцүү байсан бол 1927 оны дөрөвдүгээр сарын 15-нд 1 төгрөг 1 янчаантай тэнцүү болжээ. Энэ нь иргэдийн үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл, худалдан авах чадвар хурдан сэргэснийг илтгэж байна.

3. Үндэсний банкны үйл ажиллагаа, мөнгө, санхүүгийн тогтолцоо боловсронгуй болж, хөгжсөн үе: 1924-1991 он

3.1 Худалдаа, аж үйлдвэрийн банкны үйл ажиллагаа: 1924-1956 он

Монгол Улсад Үндэсний банкны салбар бүрэлдэж, үүсэж хөгжсөн түүх нь тухайн үед улс орны өмнө тавигдаж байсан зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээтэй нягт уялдаатай байв. Моломжамц [23] банкны салбарын түүхийг банкны хөгжлийн эхний үе (1924-1934 он), харин 1934-1954 оныг банкны хөгжлийн хоёрдахь үе буюу хамтарсан банкны удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчин, санхүүгийн чадварын хувьд бэхэжсэн үе гэж тодорхойлжээ.

1923 онд баталсан “Эдийн засгийн үндсэн бодлого” нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлсон анхны хөтөлбөр байв. Ардын

Засгийн газрын эдийн засгийн бодлого нь уламжлалт аж ахуйг өөрчлөхгүйгээр өмчийн бүх хэлбэрийг адил тэгш хөгжүүлж, тухайн нэг улсаас хараат болохоос сэрэмжлэн, дэлхийн олон оронтой эвийг сахин тэгш эрхийн үндсэн дээр харилцан ашигтай худалдаа хийх, эдийн засгийн харилцаа тогтооход чиглэж байжээ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд санхүү, мөнгө, зээлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх асуудал чухал байв. Сангийн яамнаас тус яам, Худалдаа, аж үйлдвэрийн банкныг түшиглэн 1925 онд “Мөнгөний явдлыг шинэчлэн сайжруулах комисс”-ийг байгуулжээ. Тус комисст улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, мөнгө, зээлийн бодлого боловсруулах ажлыг хариуцуулжээ. Тус комисс төгрөгийн ханшийг аажмаар чангаруулсны үр дүнд богино хугацаанд гүйлгээнээс гадаад валютыг шахан гаргажээ. Тухайн үед Монголын зах зээл дээр ашиглагдаж байсан олон төрлийн гадаад зоос, цаасан тэмдэгтүүд дотроос хятад янчаан зонхилох байр суурьтай байсан тул мөнгөний шинэчлэл хийгдэж, төгрөгийн байр суурь нэмэгдэх хүртэл албан газрын тэнцэл, улсын төсвийг янчаанаар илэрхийлж, бэлэн болон бэлэн бус гүйлгээг мөн янчаанаар хийж байжээ [23]. БНМАУ-ын улсын төсвийн тооцоог 1925 он хүртэл лангаар, 1925 оноос хятадын янчаанаар хийж байсан бол 1926 оны эцсээр тус комиссоос улсын санхүүгийн тооцоог төгрөгөөр тооцох тухай тогтоол гаргаж, Засгийн газар, Худалдаа, аж үйлдвэрийн банкинд уламжилжээ. Төгрөгийн ханш чангарч, үүрэг өсөн нэмэгдсэнээр Засгийн газрын тогтоолын дагуу 1927 оноос эхлэн байгууллага, аж ахуйн балансыг төгрөгөөр гаргах болсны дээр улсын дотор бүх тооцоог төгрөгөөр хийх болжээ. 1927 онд хуралдсан БНМАУ-ын IV Их хурлаас улсын цаасан төгрөгийг албан баталгаатай болгож, үнэ ханшийг тогтвортой байлгах чиглэлд шийдвэр гарсны дагуу Монголбанкинд хуримтлагдсан улсын алт болон валютын нөөцөд түшиглэн 1928 оны дөрөвдүгээр сарын 15-наас төгрөгийг алтан баталгаанд шилжүүлжээ. 1928 оны наймдугаар сарын 1 гэхэд төгрөг нь албан ёсны алтан баталгаанд орж, 51.8 америк центтэй тэнцэх болжээ. БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчдийн 52 дугаар тогтоолоор үндэсний мөнгөн тэмдэгтийн 40 хувийг алтаар баталгаажуулах, 10 төгрөгийн алтан зоос тус бүр 1 золотникийн 80 хувьтай тэнцэнэ гэж тогтоожээ. Мөнгөний шинэтгэл, банкны үндэс суурийг амжилттай хэрэгжүүлсэн нь тус орны аж ахуйн амьдралд нөлөөлөх эдийн засгийн чухал хөшүүргийг төрийн мэдэлд авсан явдал байв.

Гэвч Монгол, Зөвлөлтийн худалдаа, эдийн засгийн харилцаа шулуун дардан байгаагүй байна. 1926 онд Монголын талын төлөөлөгчид (*Ерөнхий сайдын жинхэнэ орлогч А.Амар, Бүх цэргийн Зөвлөлийн тэргүүлэгч Н.Жадамба*) Худалдаа, аж үйлдвэрийн банкны хувийн хөрөнгийн 50 хувь нь ЗХУ-д, үлдсэн 50 хувь нь Монгол улсад хамаардаг хэдий ч тус банкны орос удирдлага Монголын үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх чиг үүрэг зорилгыг хэрэгжүүлэхгүй байгааг Зөвлөлтийн талд уламжилж байжээ. Түүнчлэн Монголбанкинд орос иргэд олноор ажиллаж, зээлийн ихэнхийг ЗХУ-ын худалдааны байгууллагад олгож байгааг өөрчлөх зэрэг саналыг тавьж байжээ. Зөвлөлтийн тал БНМАУ-тай худалдаа-эдийн засгийн харилцааг улам өргөтгөх үүднээс 1927 онд Монголтой худалдаа

хийх хувь нийлүүлсэн "Сормонг"-ийг 1.5 сая рублийн үндсэн хөрөнгөтэйгөөр байгуулжээ.

1928 онд Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын зүүн жигүүр засгийн эрхэнд гарч, Коминтерны бодлогыг хэрэгжүүлж эхлэв. Коминтерноос тулгасан *“ядуу, дунд ардын эдийн засгийн байдлыг сайжруулах, хөрөнгөжих замыг хязгаарлах, хөрөнгөтөн феодал, лам нарын эдийн засаг, улс төрийн бааз суурийг таслах”* шийдвэрийг баримталж, Монголд нийгэм журам (социализм)-ыг шууд байгуулах чиг бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ. Энэ нь тухайн үед орлогын тэгш бус байдал өндөр, дийлэнх ардын амьжиргаа дор байсан тул тэдний дэмжлэг дээр дөрөөлж, ангийн тэмцэлд уриалсан үйл явдал болов. Энэхүү эдийн засгийн хүчирхийлэл, тэмцлийн үр дагавар Монголын түүхэнд хар өдрүүд болж үлджээ. 1929 оны арванхоёрдугаар сард дээрх зааврыг МАХН-ын Төв хороонд ирүүлсэн бөгөөд богино хугацаанд нийгэм журмыг байгуулахдаа ЗХУ-ын туршлагыг хэрэглэх тухай заасны дагуу Монголд ажиллаж байсан гадаадын пүүс компанийн үйл ажиллагааг зогсоож (*гадаадын капиталыг хөөн гаргаж*), гадаад иргэдийг хөөн гаргах ажиллагааг эхлүүлж, экспортын гол бүтээгдэхүүн – малын түүхий эд, ангийн арьс үсийг гадагш гаргах онц эрхийг улсын мэдэлд авчээ. Улсын төсөвт худалдаа, гаалийн салбараас орох орлого буурч, өргөн хэрэглээний гол нэр төрлийн барааны хомстлын улмаас үнийн “хөөрөгдөл” үүсэж, төгрөгийн худалдан авах чадвар буурах хандлага илэрч, эдийн засгийн хямрал нүүрлэв. Мөн хувийн өмч, хувийн хөдөлмөрийг устгах зорилгоор энгийн худалдаа, жин тээврийг шахах бодлого явуулж, 1928-1929 онд 8000 гаруй худалдаачин хятад иргэнийг хөөн гаргасны дээр 1929 онд Хятадын 80 гаруй худалдааны том, жижиг пүүсийн хөрөнгийг хурааж, үйл ажиллагааг нь хаасан байна. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны салбарт төрийн монополь тогтоожээ [18]. Үүний дүнд ЗХУ-аас бусад гадаад худалдаачдын экспорт, импортод эзлэх хувийн жин эрс буурч, улсын төсвийн орлогыг бүрдүүлж байсан гаалийн болон худалдааны татварын орлого буурчээ. 1929 онд Монгол, Зөвлөлтийн хооронд байгуулсан гэрээгээр хоёр орны худалдааны харилцаанд баримтлах зарчмыг тогтоосон бөгөөд Монголбанк үйл ажиллагааг ЗХУ-тай холбоотой Монголын аж ахуйн нэгжийг дэмжихэд чиглүүлэх заалт оржээ. Эдгээрийн дүнд хоёр орны хоорондын худалдааны эргэлт 1924 онд 5.1 сая рубль байсан бол 1929 онд 88.2 сая рубль болж 17 дахин нэмэгджээ. 1924 онд Монголын экспортын 13.7 хувь, импортын 13.4 хувь ЗХУ-д ногдож байсан бол 1929 онд 85.5 ба 48.3 хувьд хүрч байсан ажээ. Харин 1931 он гэхэд экспортод эзлэх хувь 99.2 хувь, импортод эзлэх хувь 90.7 хувь болж өсжээ. Ийнхүү гадаадын капитал, худалдааг шахан гаргах болсноор 1930-1940 онд экспорт, импорт харгалзан жил бүр дунджаар 11.7 хувь болон 6.2 хувиар унаж байсан бол 1940 оноос хойш тогтвортой өсөж эхэлжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1

Бодит ҮНО, экспорт болон импортын өсөлт (1919-2017 он, хувиар)

Онууд	Бодит ҮНО-ын дундаж өсөлт	Онууд	Экспортын дундаж өсөлт	Импортын дундаж өсөлт
1919-1940	5.7	1930-1940	-11.7	-6.2
1940-1950	3.3	1940-1950	13.0	6.8
1950-1960	10.7	1950-1960	7.7	11.6
1960-1970	2.7	1960-1970	17.9	18.7
1970-1980	6.1	1970-1980	16.9	16.3
1980-1990	5.1	1980-1990	5.1	5.4
1990-2000	0.1	1990-2000	-2.1	-4.0
2000-2010	5.6	2000-2010	18.4	17.9
2010-2017	5.0	2010-2017	11.4	4.5

Эх сурвалж: ҮСХ (2012). “Монгол Улс 100 жилд” эмхтгэл болон ҮСХ-ны мэдээлэлд суурилсан судлаачийн тооцоо. Энэхүү хүснэгт дэх экспорт, импортын анхны мэдээлэл нь ам.доллараар байсан болно. 1919 оны ҮНО-ыг 1919-1940 оны нийгмийн нийт бүтээгдэхүүний өсөлттэй адил байхаар тооцсон. 2000-2017 оны ҮНО-ыг 1986 оны зэрэгцүүлэх үнээр тооцохдоо 2010 оны суурьтай ДНБ-ий дефляторыг ашиглав.

Улмаар улс орныг бараа, таваарын хомстолд оруулж цай, гурил, будаа, даалимба эд бараагаар гачигдаж, амьдралын түвшин улам доройтоход хүргэжээ. Гэхдээ эдийн засгийн энэхүү хямралын үед хэрэгжүүлсэн дотоод бодлого, арга хэмжээнээс гадна 1929-1932 оны дэлхийн эдийн засгийн их хямрал худалдааны сувгаар дамжин мөн тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй.

Янзан [25] МАХН-ын зүүнтний нугалаа завхрал нь үүсэн хөгжиж байсан мөнгө, зээлийн салбарт муу нөлөө үзүүлжээ гэж дүгнэжээ. Тухайн үед хамтрал, коммуныг олноор байгуулсан нь улсын төсвийн зарлагыг их хэмжээгээр өсгөжээ. Улсын төсвийн зарлагыг нөхөхийн тулд үйлдвэр, аж ахуйн газраас төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх шаардлага үүсжээ. Гэвч худалдааны байгууллагуудын тоо буурч, алдагдалтай ажиллаж байсан тул төсвийн орлогын эх үүсвэр буурчээ. Иймд хямралын үед Монголбанк улсын төсвийн орлого, зарлагын зөрүүг нөхөх, зээлийн олголтыг дэмжих зорилгоор гүйлгээнд хэрэгцээнээс ихээхэн хэмжээний илүү мөнгийг гаргажээ. 1930-аас 1933 оны эхэн хүртэл гүйлгээнд байгаа мөнгөний үлдэгдэл 2.4 дахин өсөж, 22.2 сая төгрөгт хүрчээ. 1930 онд Монголбанкны хэлтэс, салбарын тоо 19-д хүрч өргөжив. Монголбанк аж ахуйн газруудаас санхүүгийн төлөвлөгөөг биелүүлж чадах эсэх, биелүүлсэн эсэх, барьцаа хөрөнгийг үл харгалзан зөвхөн төлөвлөгөөг баримтлан зээл (захиргаадалтын) олгох болсон нь зээлийн нөхцөлийг хянах боломжгүй болгожээ. Тухайн үед зээлийн хугацааг банкнаас тогтоож байгаагүй тул зээл тодорхой хугацааны дотор эргэж төлөгдөх ёстой гэсэн зарчмыг үгүй хийсэн нь Монголбанкны зээл, тооцооны ажиллагааг эрс өөрчилсөн бөгөөд зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг гүйлгээнд байгаа цагаан мөнгө нөхөх болж, төгрөгийн ханш эргэн унахад хүрч байжээ.

Түүнчлэн Монголбанк зээлийн хөрөнгийг аж ахуйн нэгжүүдэд бус, харин Хоршоодын холбоо зэрэгт төлөөлүүлэн олгож байсан нь аж ахуйн газар бүртэй харилцан холбоо тогтоох бололцоог хааж байжээ. Иймд банкны зээл нь аж ахуйн газруудын эргэлтийн хөрөнгийн дутагдлыг урсгалаар, хяналт шалгалтгүйгээр нөхөхөд зориулагдаж байжээ. Улмаар зээлийн хэмжээ богино хугацаанд огцом нэмэгдэж, зээлийн өрийн үлдэгдэл 1933 оны эхэнд 1930 онтой харьцуулахад худалдааны салбарт тав дахин, тээврийн салбарт 15.5 дахин, хөдөө аж ахуйн салбарт 18.3 дахин өсжээ. Үүний зэрэгцээ энгийн худалдаачин, гар үйлдвэрлэл эрхлэгчдийг шахан хавчих бодлогын улмаас тэдэнд олгох зээлийн хэмжээ эрс хумигдаж, сүүлдээ зээл олгохыг зогсоожээ. Тухайлбал, 1929 онд тэдэнд олгосон зээлийн үлдэгдэл 143.0 мянган төгрөг байсан бол 1932 оны эхэнд 12.0 мянган төгрөг болтлоо буурчээ [25]. Энэхүү мөнгө, зээлийн бодлогын уршгаар аж ахуйн газруудын хөрөнгийн зарцуулалт замбараагүй болж, тэд санхүүгийн хүндрэлд орж, банкны зээлийн бодлогын зарчим алдагдаж, улмаар Монгол орон санхүү, эдийн засгийн нөөц чадавхаа шавхаж, үр ашиггүй зарцуулжээ. Үүнээс гадна 1930-1932 онд гурван удаагийн өрийн бичгээр 4.2 сая төгрөг, ЗХУ-аас үлэмж хэмжээний зээл авч, өртэй болж үлджээ. Хамтралын хөдөлгөөн өрнөсөн хоёр жил (1931-1932 он)-д малын тоо 32 хувиар буюу 7.2 саяар хорогджээ.

МАХН-ын зүүн жигүүрийн Засгийн газрын улс төр, эдийн засгийн бодлогын улмаас аж ахуй, эдийн засгийн чадавх суларч, үндэсний баялаг, дотоод нөөцөө шавхаж, гадаад хүчин зүйлсийн улмаас эдийн засгийн хямрал даамжран хурцадсаар байсан тул 1932 онд Коминтернээс Монголд хэрэгжүүлж байсан бодлогыг өөрчлөхөөр боллоо. Энэ үед БНМАУ-ын төсвийн нэгдсэн дүн мэдээгээр ЗХУ-аас 1925-1933 онд 11.3 сая төгрөгийн зээл авсан байжээ. Энэхүү зээлийн эх үүсвэрээр Тоосгоны завод, Мод хөрөөдөх завод, Аж үйлдвэрийн комбинат, Хатгалын ноос угаах фабрик, нарийн төмөр зам, Улаанбаатар-Алтанбулагийн засмал зам зэрэг тухайн үеийн гол барилга, байгууламжийг босгосон ажээ. 1933 оны эхээр БНМАУ-аас ЗХУ-д төлөөгүй үлдсэн зээл, урьдчилгаа болон хүү нийт 14.0 сая төгрөгийн өртэй байсан бол Харилцан туслалцах хоршоо Зөвлөлтийн худалдааны байгууллагуудад нийт 15 сая төгрөгийн өртэй болсон байв. Үүнийг хоёр тал харилцан хэлэлцэн тохирч, 1934 онд Зөвлөлт Засгийн газар БНМАУ-ын төлөх 29.4 сая рублийн өр (*тухайн үед энэ мөнгө нь нэг жилийн төсвийн зарлагаас давсан дүн байв*)-ийг хүчингүй болгосон нь гадны зээл тусламжид хэт дулдуйдах суурийг тавьсан анхны үйл явдал байлаа.

Монголд социализм байгуулах гэсэн туршилт амжилтгүй болж, Монголын нийгэм бүхэлдээ хурцадмал байдалд орсон тул Коминтерн 1932 оны тавдугаар сард тусгай тогтоол гаргаж, алдааг тухайн үеийн Монголын нам, засгийн удирдлагад тохож, улмаар МАХН-ын удирдлагыг өөрчилжээ. Энэ үеийг түүхэнд “Шинэ эргэлтийн бодлого” гэж нэрлэдэг байна. Энэ бодлого нь Монголын төрөөс улс орноо хөгжүүлэх талаар 1928 оны эцэс хүртэл хэрэгжүүлсэн үндэсний ардчилсан хөгжлийн чиг шугамыг сэргээн хөгжүүлсэн хэрэг байжээ. Зүүнтний үеийн хууль, дүрэм, заавар журмыг хянан үзэж, шинэчлэн боловсруулах ажил эхэлж, 1932-1934 онд 300 шахам хууль, дүрэм, журмыг боловсруулан гаргажээ.

Мал сүргийн тоо 1940 онд онд 26.2 сая толгойд хүрч, 1932 оноос 39 хувиар өсжээ. 1933-1935 онд аж үйлдвэрийн комбинат, төв цахилгаан станц, Хатгалын ноос угаах үйлдвэр байгуулагдаж үндэсний аж үйлдвэрийн суурь тавигджээ. Энэ жилүүдэд эдийн засагт хоршоолол, хувийн худалдааны салбар хөгжих нөхцөл бүрдэж байв. Тухайлбал, улсын худалдааг төрөөс бүрэн санхүүжүүлж байсан бол хоршоолол болон хувийн худалдаа нь өмч, хөдөлмөрөө хоршигчдын санхүү, хөрөнгөнд төвлөрүүлж байжээ.


Өмчийн бүхий л хэвшлийг дэмжиж, эн тэнцүүхэн хөгжүүлэхийг чухалчилсан нь улс орны үйлдвэрлэх хүчин, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ард олны аж амьдралыг түвшинг сайжруулахад зохих нөлөө үзүүлжээ. БНМАУ-ын XVII Бага хурлын тогтоолд Монголбанкны үйл ажиллагааг шинэчлэн өөрчлөх нь чухал болохыг онцолж, банкнаас зээл олгохдоо зөвхөн улсын байгууллагуудад олгох биш, энгийн хувийн аж ахуйтан болон хувийн худалдаачдыг зээлээр ялгаварлахгүй байх, ажилчин, ардын аж ахуйнуудад зээл олгохыг онцгой анхаарах гэж тусгажээ. Энэхүү тогтоол нь зээлийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг тогтоож, зээлийн журмыг үндсээр нь өөрчилж, Монголбанкныг тус орны зээл, санхүүгийн тогтолцоо, мөнгөний гүйлгээг зохицуулан удирдах төв газар болгосон юм. Тус тогтоолд Монголбанк нь мөнгөний гүйлгээг тохируулан зохицуулж, гүйлгээнд мөнгөн тэмдэгтийг гаргах, зээл, санхүүгийн бүх төрлийн гүйлгээг хийж буй зээл, тооцооны нэгдсэн төв газар тул тус ардын аж ахуйг хөгжүүлж, бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхийг онцолжээ. Мөн банкны зээл нь тус улсын эдийн засагт бүхий л талын нөлөөг үзүүлэх хүчтэй зэвсэг бөгөөд зээлийг нарийн тодорхой төлөвлөх явдал нь түүнийг дээд зэргийн ашиг тустайгаар улс ардын аж ахуйд хэрэглэх боломжийг олгоно гэжээ. Энэ тогтоолын дагуу банкны зээл нь заагдсан нэр зориулалттай, эргэж төлөгдөх хугацаатай, барьцаалагдсан үнэ бүхий зүйлсээр заавал батлагдсан байх ёстой болов. Ингэхдээ аж ахуйн газруудын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан шууд олгох, төвлөрсөн журмаар зээл олгохгүй байхаар болжээ. Түүнчлэн банкны зээлийг тогтоосон хугацаанд нь эргүүлэн төлөөгүй, зориулалтын дагуу ашиглаагүй байгууллага, иргэнд зээл олгохыг зогсоох, үнэ бүхий зүйлийг битүүмжлэн худалдах зэрэг арга хэмжээ авах эрхийг банкинд олгожээ.

Зээлийн үйл ажиллагааг шинэчлэн өөрчилсөн нь тэр даруйдаа зохих үр дүнгээ өгөв. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний хэмжээ 1934 оны эхэнд өмнөх оны мөн үеэс 22.5 хувиар буурч, 17.2 сая төгрөгт хүрчээ. Зээлийн үйл ажиллагааны арга, хэлбэрийг шинэчлэн өөрчилсөн нь аж ахуйн газруудын санхүүгийн байдлыг бэхжүүлж хөрөнгийн ашиглалтыг сайжруулжээ. 1934 онд хуралдсан БНМАУ-ын XVII Бага хурлаас тус улсын нийт санхүүгийн байдлыг хэлэлцээд, Монголбанкны цаашдын зорилтыг ардын аж ахуй, энгийн худалдаанд зээллэг олгох явдлыг өргөн бэхжүүлэх, зээлийн шинэтгэлийг үргэлжлүүлэн бэхжүүлэхээр даалгасан байна. 1938 онд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хуралд ардын аж ахуйтанд олгох урт хугацааны зээлийг нэмэгдүүлэх тухай асуудал хэлэлцүүлж, 1.5 сая төгрөгийн урт, 1.5 сая төгрөгийн богино хугацаатай зээл олгох зөвшөөрөл авчээ. 1938 оны байдлаар нийт зээлийн

өрийн үлдэгдэл 8.77 сая төгрөг байсны 3 сая орчим нь малчдад олгосон зээл байжээ. 1930-1940 онд зээл жилд дунджаар 20 хувиар өсөж байжээ (Зураг 2). Улсын худалдааны гүйлгээ нэгэнт батжин тогтсон тул 1938 оны нэгдүгээр сараас эхлэн комиссын худалдааны хэлбэрээр ажиллаж байсан энгийн худалдаачдыг дэмжих үйл ажиллагааг зогсоожээ. Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд Монголын улс төрийн зүтгэлтнүүдийн бие даасан бодлого, үйл ажиллагаа дахин идэвхэжсэн боловч улс төрийн хүчирхийлэл гаарснаар ард олны итгэл алдарч, эдийн засаг, аж ахуйн бүх салбарын хурд буурахад хүрчээ.

Зураг 3

Эдийн засгийн өсөлт (салбараар, хувиар)



Эх сурвалж: УСХ

1940 онд хуралдсан Улсын VIII их хурлаас улсын эдийн засгийн хөгжлийг цаашид эрчимжүүлэх, ялангуяа мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлж, үйлдвэр, барилга, зам тээврийн салбарыг хөгжүүлэх, санхүүгийн сахилга, хяналтыг дээшлүүлэх зорилт тавьжээ. Сайд нарын Зөвлөлийн 1940 оны тогтоолоор хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Монголбанкинд төвлөрүүлэн хянаж гүйцэтгэх, банкны кассын төлөвлөгөөг улирал бүр зохион Сайд нарын зөвлөлөөр батлуулж байхаар тогтсон байна.

Дэлхийн II дайны үед БНМАУ-ын мөнгө, зээлийн салбар үйл ажиллагаагаа нягт нямбай явуулж, улс ардын аж ахуйг шаардлагатай мөнгөн хөрөнгөөр хангах, хэмнэлтийг чанд хатуу дэглэм барьж байлаа. Энэ үед Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкны үйл ажиллагаа улсын худалдаа бэлтгэлийн арга хэмжээг зээлийн эх үүсвэрээр, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууллагын үйлдвэрлэлийн хэрэгцээг хөрөнгөөр хангахад чиглэж байв. 1941 оноос эхлэн аж ахуйн салбарын жил тутмын төлөвлөгөө зохиож, хувийн аж ахуйн өсөлт, бэлтгэн нийлүүлэлтийн жилийн хяналтын тоо өсөж, дотоодын хэрэгцээг өөрийн эх үүсвэрээр хангах,

ЗХУ-д гаргах экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилт тавьжээ. Энэ зорилтыг хэрэгжүүлэх үүднээс улс ардын аж ахуйд олгох зээлийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлжээ. Үүний үр дүнд орон нутгийн түүхий эдийг ашиглан ажиллах улсын үйлдвэр 20 гаруй, хоршооллын үйлдвэр 30 орчмыг байгуулж ашиглалтад оруулжээ. 1941-1943 онд аж үйлдвэрт улсаас 100 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, ялангуяа хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн салбарыг бэхжүүлэхэд түлхүү анхаарчээ. Энэ нь дайны улмаас өргөн хэрэглээний барааны хэмжээ хязгаарлагдмал болсныг дотоодын үйлдвэрлэлээр нөхөх, наад зах нь хүнсний зүйлийн 50 хувийг, ойролцоогоор тус улсын жилийн хэрэгцээний 2/3-ийг эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангах боломж бүрджээ. 1943-1948 онд Монголбанк энэ хэрэгцээнд 1.9 сая төгрөгийн урт хугацаатай зээл олгосон байна. Дэлхийн II дайны он жилүүдэд нийт зээл болон эдийн засгийн өсөлт саарч, гадаад худалдаа нэмэгдэж байсан бол 1950 оноос эдийн засгийн өсөлт хүчтэй эрчимжсэн байна (Зураг 3).

Улсын сангийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар 1941 онд “Алт малтаж гаргах арга хэмжээний тухай” тогтоол гаргаж, мөн онд 100 кг алт олборлохоор шийдвэрлэжээ. Ингэхдээ улсад тушаах алтны үнийн 50 хувийг бараагаар олгох, 1000 (99.99) сорьцтой 1 грамм алтыг 4 төгрөг 47 мөнгөөр үнэлж авах, үүнийг нь Монголбанк уурхайн трестээс авахдаа нэг граммыг 6 төгрөг 50 мөнгөөр үнэлж авахаар тогтоожээ. Энэ үеэс л Монголбанк гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх зорилгоор алт худалдан авч эхэлжээ.

Мөнгө, зээлийн салбарын чухал нэг зорилт нь бэлэн бус тооцоог өргөжүүлэх, аж ахуйн газар хоорондын зардлын гүйлгээг хялбарчлах явдал байв. Дайны үеийн өөр нэг чухал зорилт нь сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг татан авч улсын ардын аж ахуйн хэрэгцээнд ашиглах явдал байв. 1942 оноос улсын эх хөрөнгийн хонжворт сугалаа таван удаа явуулж, 25.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. 1931-1944 онд Улсын банкнаас улсын үйлдвэр, аж ахуйн газарт нийт 26.6 сая төгрөгийн зээл олгожээ.

1947 онд БНМАУ-ын улс ардын аж ахуй, соёлыг 1948-1952 онд хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөг баталжээ. Үүнээс хойш 1990 он хүртэл БНМАУ нийт найман удаа таван жилийн төлөвлөгөө зохиож баталсан байна. 1948-1955 онд социалист бараг бүх орнуудтай худалдаа төлбөрийн хэлэлцээр байгуулсан нь Улсын банкны гадаад тооцооны ажиллагааг системтэйгээр өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг бүрдүүлжээ.

1948 оноос улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөт зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулахад банкны үйл ажиллагаа чиглэжээ. Анхны таван жилийн төлөвлөгөөний жилүүдэд банкнаас олгосон зээл 40 орчим хувь, банкны кассын орлого, зарлагын гүйлгээ 20 гаруй хувь өсөж, бэлэн мөнгөний гүйлгээ 20 шахам хувь буурч, мөнгөний эргэлт нэлээд нэмэгдсэн байна.

Үндэсний боловсон хүчнийг бэлтгэх талаар анхаарч ажилласны үр дүнд 1954 он гэхэд банкны ажилтны 98 хувь нь монгол иргэдээс бүрдэх болсон байна. Үүний зэрэгцээ бүх аймаг, томоохон сууринд Монголбанкны салбартай болж, мөнгө, зээл, төлбөр тооцоогоор үйлчлэн улсын хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээг төлөвлөгөөтэйгөөр зохицуулдаг болж, байгууллага хооронд тооцооны дэвшилтэт хэлбэрүүд, бэлэн бус төлбөрт тооцоо нэвтэрч эхэлжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс дангаараа Монголбанкны үйл ажиллагааг явуулах удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчин, санхүүгийн нөхцөл бүрдээд байжээ [23].

3.2. Улсын банкны үйл ажиллагаа: 1954-1991 он

Моломжамц [23] Монголын банкны салбарын түүхийн 1954-1990 оныг Монголын тал өөрийн хүч хөрөнгө, боловсон хүчинд түшиглэн нэг тогтолцоот банкны систем хөгжсөн үе гэж тодорхойлжээ.

1950-иад онд Монголын улс төр, нийгмийн амьдралд томоохон өөрчлөлт гарав. ЗХУ-ын дотоодод гарсан өөрчлөлт, социалист систем бүрэлдэн бий болсон явдал нь Монголын нийгмийн амьдралд ихээхэн нөлөө үзүүлэв. Монголд үндэсний сэхээтний нэгэн шинэ үе бий болж, тэдний дундаас төрөн гарсан анхны эрдэмтэд Монгол орны хөгжлийн чиг хандлага, социализм байгуулах онол үзэл баримтлалыг боловсруулан дэвшүүлэх болсон байна. 1954 онд МАХН-ын XII Их хурал хуралдаж, БНМАУ-ын түүхэн хөгжлийн үе шат, эдийн засаг-нийгмийн харилцааны шинж чанарыг тодорхойлж, цаашид улс ардын аж ахуйн салбарыг ямар харьцаатайгаар хэрхэн хөгжүүлэх талаарх асуудлыг дэвшүүлэн тавьжээ. Социализмын үндсийг байгуулж байгаа түүхэн үеийг: (i) 1921-1940-өөд оны хүртэл үеийг хамрах хувьсгалын ардчилсан шат; (ii) 1940 оноос одоог хүртэл үргэлжилж байгаа социалист хувьсгалын үе шат болно гэж дүгнэжээ.

Монголбанк 1924-1954 оны хоорондын 30 жилийн хугацаанд БНМАУ-ын мөнгөн гүйлгээ, зээл, тооцоо, касс, санхүүжилтийг бүхэлд нь хамарсан үндэсний мөнгө, зээлийг системийн нэгдсэн төв болж, боловсон хүчин нь бэхжиж, бүх аймаг, зарим томоохон хот, суурин газарт өөрийн салбартай болж, үндэсний боловсон хүчин бэлтгэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банкныг БНМАУ-ын улсын банк болгох гол нөхцөлийг бүрдүүлжээ [25].

1954 онд ЗХУ-аас Худалдаа, аж үйлдвэрийн банкинд оруулсан өөрийн хувь хөрөнгөө Монголын талд шилжүүлэн өгснөөр тус банк БНМАУ-ын Засгийн газрын мэдэлд бүрэн шилжлээ. 1954 оны дөрөвдүгээр сарын 12-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкныг өөрчлөн зохион байгуулж, “БНМАУ-ын Банк” гэж нэрлэхээр тогтож, Улсын банкны дүрмийг баталжээ. Дүрэмд БНМАУ-ын банк (Улсын банк) нь Монголбанкны суурь дээр байгуулагдсан эмиссийн ганц банк бөгөөд богино, урт хугацаатай зээл олгох, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, тус улсын гадаад, дотоод ажил гүйлгээ эрхлэх тооцооны ба кассын төв болно гэж заажээ. Мөн дүрмээр тус орны мөнгө, зээлийн тогтолцоог зохицуулан зохион байгуулж, удирдах, үндэсний валют-төгрөгийн худалдан авах чадварыг бэхжүүлэх,


улс ардын аж ахуй, ард иргэдийг бэлэн мөнгөөр үйлчлэх, бэлэн мөнгийг хуримтлуулах, улсын төсвийн кассын үүргийг гүйцэтгэх, бэлэн мөнгөний зарцуулалтад төгрөгөөр тавих хяналтыг хариуцан явуулах бүрэн эрх, үүргийг Улсын банкинд олгожээ. Улсын банкны төв аппарат нь түүний ерөнхий хороо байхаар заажээ. Улсын банкны Ерөнхий хороо нь өөрийн салбаруудын зээл тооцоо, санхүүжилт, бүртгэл, мөнгөний гүйлгээний бүх ажиллагааг зохицуулан явуулахад төвлөрсөн нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох заавар, заалт, удирдамжийг гаргадаг байв. 1954 оны байдлаар Улсын банк нь 22 хэлтэс, салбар 13 касстай байв.

Социалист байгуулалтын жилүүдэд БНМАУ-ын Улсын банкны Ерөнхий хороо нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт зохицсон нэгдмэл удирдлагатай, төвлөрсөн зохицуулалттай улсын банкны систем болж тогтжээ. Социалист аж ахуйг төлөвлөгөөтэйгөөр хөгжүүлж буй нөхцөлд улс ардын аж ахуйн мөнгөн хөрөнгийн чөлөөт нөөцийг зээлийн журмаар хуваарилан олгох, эргүүлэн төвлөрүүлэх үйл ажиллагаа нь мөн л төлөвлөгөөгөөр зохицуулагдаж байв. Үйлдвэр аж ахуйн газар нь үйлдвэрлэлийн онцлог, нөөц, түүхий эд бараа, материалын ханган нийлүүлэлт, татан авалтын ажиллагааны онцлог зэргээс шалтгаалж, эргэлтийн хөрөнгийг тогтоосон нормативоос илүү бэлтгэх явдал гарах бөгөөд үнийг банкны богино хугацаат зээлээр нөхөж байжээ. Үйлдвэр аж ахуйн газар, байгууллагад зээлийг хүүтэйгээр олгох зарчим нь зээлийн хөрөнгийг үр ашигтай зөв ашиглан тогтоосон хугацаанд эргүүлэн төлөх сонирхлыг өндөржүүлж, улмаар аж ахуйн тооцоог бэхжүүлэх, тэдний эргэлтийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах хөшүүрэг болох ёстой байв. Аж ахуйн газрын үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ өсөн нэмэгдэхийн хэрээр зээлийн хэмжээ өсжээ. Тухайлбал, улс ардын аж ахуйн салбарт олгосон богино хугацаатай зээлийн хэмжээ 1951-1956 онд хоёр дахин, 1956-1961 онд 1.6 дахин, 1961-1966 онд 1.4 дахин өссөн байна. Kaser [18] Монголын аж үйлдвэрийн хувьсгал 1950-аад оны сүүлээс хүчээ авсан гэж дүгнэжээ.

Атар газрыг эзэмшиж, газар тариаланг хөгжүүлэх замаар хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, эдийн засгийн хөгжлийг хурдасгах шаардлагын дагуу атрын гурван удаагийн аян өрнүүлжээ. Атрын анхны аяныг явуулах тогтоолыг 1959 оны гуравдугаар сард МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлаас гаргасан бол хоёр дахь аян 1976 оноос өрнөжээ. Атрын аян өрнөж байсан он жилүүдэд үр тарианы тариалсан талбайн хэмжээ нэмэгдэж байсан бол ургацын хэмжээ хэлбэлзэлтэй байв (Зураг 4). Хөдөө аж ахуйн салбар 1966 он болон 1967-68 оны ган, зудын нөлөөгөөр томоохон уналтад орж байжээ (Зураг 3). Тухайлбал, Hart [16] нийт ажиллах хүчний 2/3 нь, нийт экспортын 9/10, нийт үндэсний орлогын 1/3-ийг мал аж ахуйн салбар бий болгож байгааг онцолж, харин 1966 онд хөдөө аж ахуйн зорилтууд биелээгүйг онцолж байв. Тухайлбал, 1965-66 онд малын тоо 1.8 сая толгойгоор хорогдож, 22 сая болсон бол үр тарианы үйлдвэрлэл 16 хувиар унасан байна.

Зураг 4

Үр тарианы тариалсан талбай, хураасан ургацын хэмжээ (1960-2017)



Эх сурвалж: ҮСХ (2012). “Монгол улс 100 жилд” эмхтгэл болон ҮСХ-ны мэдээлэлд суурилсан судлаачийн тооцоо

1960-аад онд хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд зээлийн хөрөнгийн хувийг нэмэгдүүлэх нь манай орны хөгжлийг тэргүүний социалист орнуудын хэмжээнд хүртэл өөд татах улс ардын аж ахуйг хөгжүүлэх хурдцыг ханган шийдвэрлэгч зам мөн гэж үзэж байв. 1960 оноос хөдөө аж ахуйн нэгдлүүдэд улсаас зээлийн системээр дамжуулан үзүүлэх санхүүгийн туслалцааг өргөтгөх, нэгдэлд олгох урт, богино хугацаатай зээлийн нэр төрлийг олшруулах, хугацааг нь уртасгах, нэгдлийн эргэлтийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих банкны хяналтыг сайжруулахтай холбогдсон арга хэмжээнүүдийг авчээ. Улсаас хөдөө аж ахуйн нэгдэлд олгох урт хугацаатай зээлийн хугацааг 3-10 жил хүртэл болгов. 1960-1970 оны үед ган зуд байнга тохиолдож, хөдөө аж ахуйн нэгдлүүдийн төлбөрийн чадвар суларч, ахиухан зээл авч, ган зуд болсон шалтгаанаар төлбөрөөс хөнгөлүүлэх сонирхол өндөр байжээ.

1963 онд банкны хяналтыг улам хүчтэй болгох тухай Засгийн газрын шийдвэр гарч, үйлдвэр, аж ахуйн газруудыг үндсэн ажиллагаа, ашгийнх нь чанарын үзүүлэлтээр ялгаварлан зээлжүүлэх, урамшил, шимтгэл үзүүлэх болжээ. 1964 онд Улсын банкны Ерөнхий хорооны бүтцэд томоохон өөрчлөлт хийж, үйлчилгээний ажлыг тусад нь гаргаж, Улаанбаатар хотын Банкны салбарыг байгуулжээ. Түүнчлэн мөнгөний эргэлтийг хурдасгаж, банкны үйлчилгээг улс ардын аж ахуйн салбар, хөдөлмөрчдөд ойртуулах зорилгоор 1965 онд аймгийн төвөөс 100 км-ээс хол орших сумдад банкны тооцооны касс байгуулахаар болсон нь санхүүгийн хүртээмжийг сайжруулах чухал алхам байв. 1966-1982 онд төвийн эрчим хүчний системийг бий болгож, Дархан, Эрдэнэт, Багануур, Бор-Өндөр зэрэг аж үйлдвэрийн шинэ төв үүсэж, үйлдвэрийн бүтэц байршилд ихээхэн өөрчлөлт гарав. Банкны богино хугацаатай зээл нь үйлдвэр, аж ахуйн газрын эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн чухал бүрэлдэхүүн болж байв.

1972 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор богино хугацаат зээлийн хүүг зээл олгогдож буй объектуудын эдийн засгийн шинж чанар, түүний хугацааны байдлыг харгалзан ялгавартай тогтоожээ. Ингэхдээ хугацаандаа байгаа богино хугацаатай зээлийн хүүг 2-6 хувь, бүх төрлийн хугацаа хэтэрсэн богино хугацаатай зээлийн хүүг жилийн 8 хувийн хүүтэй байхаар тогтоожээ. Аж үйлдвэрийн газрын банкны богино хугацаатай зээлийн үлдэгдэл 1972 онд 1961 онтой харьцуулахад 2.6 дахин өссөн байна. 1973 он гэхэд улсын хэмжээнд нийт 220 гаруй тооцооны касс ажиллаж, ихэнх сум, нэгдэл, суурин газрыг хамарч байв. Улсын банкнаас барилга угсралтын байгууллагад олгосон богино хугацаатай зээлийн хэмжээ 1974 онд 1968 оныхоос 2.7 дахин өсөж, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн 30 гаруй хувийг банкны богино хугацаатай зээлээр санхүүжүүлэх болжээ.

1980-иад оны эхэнд Улсын банк нь аж ахуйн мөнгөн касс, эмисс, зээл, хөрөнгө оруулалт, бэлтгэл тооцооны нэгдсэн төв болж, нийт аймаг, хотод банкны 21 контор, 25 салбар хэлтэс, 350 гаруй хадгаламж, тооцооны касс ажиллаж, тэдгээрт 2000 гаруй мэргэжилтэн ажиллаж байжээ. Нийгмийн үйлдвэрлэлийн цар хүрээ өсөхийн хэрээр Улсын банкны гүйцэтгэх ажил, үйлчилгээний хэмжээ нэмэгдэж, түүний гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгджээ. Тухайлбал, аж ахуйд 1955 онд 1551.3 сая төгрөгийн богино хугацаатай зээл олгож байгаа бол 1982 онд 19870.9 сая төгрөгт хүрч 12.8 дахин өсжээ. Харин урт хугацаатай зээл 1982 онд 1955 онтой харьцуулахад 22.8 дахин, 1975 онд 3.3 дахин өсжээ [25].

Улс ардын ахуйд ажил үйлчилгээний болон бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэн гаргах хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 1983 оны нэгдүгээр сараас Улсын банкны зээлийн хүүг өөрчилжээ. Үүнд богино хугацаатай зээлийг зориулалтаар нь ангилж хүүг нь 0.5-4 хувиар, хугацаа хэтэрсэн тохиолдолд 10 хувиар тус тус тогтоожээ. Түүнчлэн 1983 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Улсын банкны Ерөнхий хороонд “Үнэт зүйлс, эрдэнэсийн сангийн улсын фонд”-ыг байгуулсан байна. Энэ үеэс Эрдэнэсийн сан Улсын төв банкны мэдэлд харьяалагдах болжээ.

БНМАУ-ын гадаад харилцаа, түүний дотор худалдаа, эдийн засгийн гадаад харилцаа өсөж байгаатай уялдаж, Улсын банкны гадаад харилцаа, ялангуяа социалист орнуудын банктai харилцах харилцаа өргөжжээ. Тухайлбал, эдийн засгийн харилцах туслах зөвлөлийн гишүүн орнуудын эдийн засгийн хөгжлийн бодит шаардлагын улмаас Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк, Олон улсын хөрөнгө оруулалтын банкиг байгуулж, Улсын банк үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож, 1983 он гэхэд БНМАУ-ын банк гадаадын 70-аад банктai шууд харилцаатай байжээ.

1980 оны сүүлээр эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, үр дүнгийн норматив үзүүлэлтийг үндэслэн мөнгөний гүйлгээг зохицуулах арга хэмжээ авч, банкны салбарыг томоохон сумдад байгуулж байв. 1990 он гэхэд хөдөө аж ахуйн 255 нэгдлийн 105 нь өртэй, тэдгээрийн 60 орчим нь ойрын үед өрөө төлж чадахааргүй байдалд хүрсэн байжээ. Энэхүү дотоод өр, зээлээс гадна ЗХУ болон

бусад социалист орнуудаас их хэмжээний тусламж, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авчээ. Зөвхөн ЗХУ-аас Монголын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд 1971-1975 онд 450 орчим сая орчим рублийн зээл, тусламж авч байсан бол 1976-1980 онд 1.4 тэрбум, 1981-1985 онд 3.2 тэрбум, 1986-1990 онд 3.5 тэрбум шилжих рублийн зээл, тусламж авч ашиглажээ. 2003-2010 онд энэхүү “Их өр”-ийн 98 орчим хувийг чөлөөлүүлж, 2 хувь (250 сая ам.доллар+3.8 сая ам.доллар)-ийг төлсөн билээ⁵ [6].

Өөрчлөн байгуулалт, социалист орнуудад өрнөсөн үйл явц БНМАУ-д ардчилсан хувьсгал гарах гол нөхцөлийг бүрдүүлжээ. Социалист хамтын нөхөрлөл задрахын хэрээр БНМАУ-ын эдийн засгийн хэлхээ холбоо суларч, тусламж дэмжлэг зогсов. Улс төрийн шинэ хүчнүүд нэг намын ноёрхлыг халах, олон намын систем тогтоох, хүний эрхийг хангах талаар удаа дараа шаардлага тавьж, жагсаал цуглаан зохион байгуулав. 1990 оны гуравдугаар сарын 9-ний өдөр эрх баригч МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох болсноо мэдэгджээ. 1990 оны гуравдугаар сард Ардын Их Хурал (АИХ)-ын 11 дэх удаагийн сонгуулийн VIII чуулганаас “*БНМАУ-ын төр, нийгмийн удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог МАХН мөн*” гэсэн Үндсэн хуулийн заалтыг хассан бол хоёр сарын дараа АИХ-ын IX чуулганаас “БНМАУ-ын улс төрийн намуудын тухай” хуулийг баталснаар Монгол Улсад олон намын тогтолцоо бодит үйл хэрэг болжээ.

Улс төр, нийгмийн тогтолцооны өөрчлөлт нь эдийн засгийн тогтолцооны өөрчлөлттэй давхар явагдаж, Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн юм. 1990 оны долдугаар сарын 29-нд БНМАУ-д анх удаа чөлөөт ардчилсан сонгууль боллоо. Хууль тогтоох байгууллагад олонхын санал авсан МАХН Засгийн газраа дангаараа бүрдүүлэх бололцоотой байсан боловч Ерөнхий сайд Д.Бямбасүрэн улс төрийн шинэ хүчнүүдэд хамтран ажиллах санал тавьжээ. Шинэ засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлд мөнгө, үнэт цаасны зах зээлийг үр ашигтайгаар зохион байгуулж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, хуримтлалыг урамшуулахуйц зээл, банкны хувь хүүний бодлого явуулна гэж заажээ. Түүнчлэн олон улсын санхүү, эдийн засгийн байгууллага, гадаадын банкнуудтай үр ашигтай харьцаж чадахуйц зээлийн механизм бий болгож, хадгаламжийн хүү, зээлийн хүүний бодлого, төлбөрийн журмыг зохицуулах, үндэсний валютын худалдан авах чадварыг тогтвортой байлгахад чиглэсэн цогц арга хэмжээ авч, ойрын жилүүдэд дотооддоо хөрвөх чадварыг хангах, гүйлгээнд мөнгө гаргах үйл ажиллагаанд төрийн хяналт тогтоож, мөнгөний ханш буурахыг хязгаарлах механизмыг хүчтэй болгох, аж ахуйн банкнууд байгуулж, хувийн болон хоршооллын банкнуудын найдвартай ажиллагааг хангахад төрөөс дэмжлэг үзүүлж, гарааны нөхцөлийг бүрдүүлэхэд тусална гэж заажээ.

⁵ Энэ нь эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чухал үйл явдал байсан боловч 2018 оны эцсийн байдлаар Монгол Улс дахиад 28.7 тэрбум ам.долларын гадаад өртэй байна.

Өмчийн олон хэлбэр эргэн үүсэж хөгжих эхлэл тавигдсан нь банкны задралыг үүсгэж, хуучин тогтолцоог эвдэх эхлэлийг тавив. Зарим залуу эдийн засагчид (М.Энхсайхан, Д.Ома) чөлөөт зах зээлийн нөхцөлд банкны тогтолцоо ямар бүтэцтэй байх загварыг санал болгож байсан нь төв банк болон арилжааны банк гэсэн хоёр шатлалт тогтолцоонд шилжих явдал байв. Үүнээс хойш төд удалгүй арилжааны банкнууд олноор байгуулагдсан байна. 1990 оны долдугаар сарын 27-нд Улсын банкны Ерөнхий хорооноос “Үйлдвэрлэлийн хувь нийлүүлсэн банк”-ийг байгуулахыг зөвшөөрснөөр БНМАУ-д анхны арилжааны банк байгуулагджээ. Тус оны есдүгээр сарын 18-нд “Монгол Хоршоо” банк, аравдугаар сарын 24-нд “Монгол даатгал банк” байгуулагджээ. 1991 онд банкны тухай хууль гарч төв банк байгуулагдах хүртэл Улсын банкны Ерөнхий хорооноос тэнцэл тусгаарлаж, Худалдаа, хөгжлийн банк, Хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлийн банк байгуулагдсан байна. Мөн Хөдөө аж ахуйн банк, Авто зам банк байгуулагджээ.

4. Хоёр шатлалт банкны шинэ тогтолцоо үүсэж хөгжсөн үе: 1991 оноос эдүгээ хүртэл

4.1 Эдийн засгийн шилжилтийн үе: 1991-2000 он

1991 онд БНМАУ-ын банкны тухай хууль батлагдаж, тус хуульд БНМАУ дахь банкны тогтолцоо нь БНМАУ-ын төв банк, арилжааны банкнаас бүрдэнэ хэмээн зааж, төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, эмиссийн үйл ажиллагаа явуулах, арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих, улсын валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Монголбанк байгуулагдсанаар Төв банк, арилжааны банк гэсэн хоёр шатлал бүхий банкны шинэ тогтолцооны үндэс тавигджээ. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогыг макро түвшинд хэрэгжүүлэх, эдийн засгийг мөнгөөр дамжуулан төрөөс зохицуулах гол субъект нь зах зээлийн нөхцөлд төв банк болжээ. БНМАУ-д хувь нийлүүлсэн, хязгаарлагдмал хариуцлагатай, гадаадын хөрөнгийн оролцоотой төрийн болон хувийн арилжааны банк байгуулах, түүний зэрэгцээ гадаадын банк, түүний салбар үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрчээ.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилт амар хялбар байгаагүй энэ үед Монголбанк нь өөрийн шинэ чиг үүрэг болох төв банкны үйл ажиллагааг эрхлэн явуулах сорилттой нүүр тулсан юм. 1991 оны эхээр Засгийн газар өмч хувьчлах бэлтгэл ажлыг хангаж, улс орны эдийн засгийн хөгжлийн онцлог, тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохируулан өмчийг үндсэнд нь хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлалаа. 1989 онд үндэсний орлогын 90 хувийг улсын үйлдвэрийн газрууд бий болгож байсан тул хувьчлалын дараагийн хоёр жилд хөдөө, аж ахуйн салбараас бусад салбар уналтад оров (Зураг 5).


Эдийн засгийн шилжилтийн энэ үед үүссэн нөхцөл байдлыг дотоод нөөц бололцоогоор дангаар шийдвэрлэх боломжгүй байсан тул Монгол улс олон улсын санхүүгийн байгууллагуудад гишүүнээр элсэж, тэдгээрийн тусламжийг авч эхэллээ. Тухайлбал, Монгол улс 1991 онд Олон улсын валютын сан (ОУВС),

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүн орноор элсэж, бусад томоохон банктай хамтран ажиллаж эхэлжээ.

Зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний он жилүүдэд буюу 1991-1993 онд эдийн засаг жил бүр дунджаар 7 орчим хувиар унав. Ялангуяа, боловсруулах, худалдаа, үйлчилгээ, уул уурхай, барилгын салбарууд голлон өртсөн ба эдийн засгийн уналтыг даган бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт сөрөг байжээ (Зураг 5). Хэдийгээр нийгэм, эдийн засгийн амьдралд олон чухал эхлэлийг тавьсан боловч дотоодын үйлдвэрлэл талаас нь авч үзвэл 1991-2000 оны энэ үе нь Монголын эдийн засгийн хувьд “алдагдсан 10 жил” байв.

Зураг 5

Эдийн засгийн өсөлт (салбараар)



Эх сурвалж: YCSX

1991 оны нэгдүгээр сарын 15-нд “Эдийн засгийг зах зээлийн зохицуулалтад шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” хэмээх БНМАУ-ын Засгийн газрын 20 дугаар тогтоолоор мөнгөний ханш өөрчлөгдөж, маргааш нь бүх бараа, бүтээгдэхүүний үнэ хоёр дахин нэмэгдэж, ихээхэн хэмжээний бэлэн мөнгө хадгалж байсан иргэд хохирчээ. Харин иргэдийн хадгаламжийг хоёр дахин өсгөж өгчээ. Энэхүү арга хэмжээг шилжилтийн эдийн засагт “шок эмчилгээ” гэж нэрлэдэг. Үнэ, тарифын бүрдэлтийг 1992 оны эцэс гэхэд үндсэнд нь чөлөөт тогтолцоонд шилжүүлсэн нь чухал алхам болсон гэж үздэг. Гэхдээ зах зээлийн

харилцаанд шилжих явцад ийнхүү үнийг чөлөөлснөөр Монгол улс гиперинфляцитай нүүр тулсан бөгөөд 1991 онд 53 хувь, 1992 онд 325 хувь, 1993 онд 183 хувийн инфляцитай байв (Зураг 6).


Засгийн газар 1991 оны аравдугаар сарын 4-ний өдөр ОУВС-гийн эдийн засгийг тогтворжуулах зорилготой Стэнд-бай хөтөлбөрийг хэрэгжүүлснээр донор орнуудын зээл, тусламжийг ашиглах нөхцөлийг бүрдүүлж байв (Зураг 7). Инфляци өндөр түвшинд хүрсэн байсан тул ОУВС-гийн Стэнд-бай хөтөлбөрийн хүрээнд хадгаламжийн хүүг нэмэгдүүлэх, банкуудын зээлд хязгаар тогтоох замаар мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлсний зэрэгцээ татварын салбарыг өөрчлөх байдлаар төсвийн бодлогыг хумьж байсан нь ОУВС-гийн стандарт бодлогын арга хэмжээ бөгөөд төсөв, мөнгөний хатуу бодлого нь дотоод эрэлтийг хумих замаар төлбөрийн тэнцлийг сайжруулж, валютын ханшийн сулрах дарамтыг бууруулж, инфляцийг тогтворжуулахад чиглэдэг. Энэ дагуу ДНБ-ий үйлдвэрлэл буурч, барааны хомстол газар авч, мөнгөний нийлүүлэлт эрс нэмэгдэж, улсын төсвийн алдагдал нэмэгдэж, барааны үнэ өсөж, гадаад валютын нөөцгүй болж, хугацаа хэтэрсэн гадаад өр төлбөр хуримтлагдаж, ард түмний амьжиргааны түвшин буурч байгаатай уялдуулан 1992, 1993 онд Төв банкнаас харьцангуй хатуу бодлого явуулахад голлон анхаарчээ [24].

Эдийн засгийн хүндрэлийн үед макро эдийн засгийн тогтворгүй байдлаас гадна банкны салбарт ч хүндрэл бий болж байв. Төв банк байгуулагдахаас өмнө буюу 1990 оны сүүлээр байгуулагдсан банкнууд тодорхой уялдуулж зохицуулсан бодлогогүйгээр бага хүүтэй зээлийг хяналт муутайгаар их хэмжээгээр олгосны улмаас 1990-1991 онд мөнгөний нийлүүлэлт үндсэндээ зохицуулалтгүй явагдаж, хүмүүсийн гар дээрх бэлэн мөнгө хурдан өсөж, бараа таваарын хомстолтой үед инфляци эрчимжих нэг нөхцөл болжээ [22]. Төрийн зохицуулалт сул нөхцөлд гүйлгээнд бий болсон мөнгөний тоо хэмжээг үндэсний үйлдвэрлэл, импорт бүрэн гүйцэж чадахгүйгээс үндэсний мөнгөн тэмдэгт суларч, улмаар долларжилт нэмэгдэж, энэ нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлжээ. Ийнхүү эдийн засгийн уналт, гипер-инфляци давхцаж стагфляци бий болсноор иргэдийн амьжиргаанд том цохилт болж байв.

Моломжамц [24] мөнгө, зээлийн тогтолцоонд бий болсон хямрал, инфляцийн илрэл нь зөвхөн шилжилтийн эхэн үеийн 3-4 жилд гэнэт бий болсон үзэгдэл бус, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн оршин тогтнох хүч суларч эхэлсэн 1980-аад оны дунд үеэс улбаатай гэж дүгнэж байв. Тэрээр захиргааны аргаар хяналтыг хэдий чинээ чангалбал зах зээлийн нийлүүлэлт төдий чинээ хумигдаж, нэг талаас хэрэглэгч бараа нийлүүлэлтийг, нөгөө талаас үйлдвэрлэгчид мөнгө нийлүүлэлтийг нэхэх хоёр талын нэхэлт давхцаж, зах зээлийн тэнцвэр алдагдаж байсныг онцолж байв. Мөн тэрээр шилжилтийн эхэн үе дэх инфляци нь эрэлт, нийлүүлэлтийн аль алины олон хүчин зүйлийн хам шинж чанартай гэж үзэж байсан бөгөөд мөнгөний сонгодог тооны онол ёсоор мөнгө, түүний тоо хэмжээг үнэ-өртөг, ханш, үйлдвэрлэлээс салгах үндэсгүй тул мөнгөний хатуу бодлого нь инфляцийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцолжээ.⁶

Зураг 6

ОУВС-гаас Монгол Улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд




Эх сурвалж: ОУВС-гийн цахим хуудас

1994 оны байдлаар инфляци “давхиа” байдлаас “шогшоо” байдалд шилжих зааг үе дээр ирлээ гэж дүгнэж байв. Гэхдээ зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц гүнзгийрэх тутам дан ганц мөнгөний тоон онол, арга зүйн зохицуулалтыг удаан хугацаанд хэрэглэх нь инфляцийн өндөр өсөлтийг түр зуур барихаас бус, эдийн засгийн бүрэн либералчлах, өсөлтийг нь хангах, үйлдвэрлэлийг дэмжихэд төдийлөн сайн нөлөө үзүүлж чадахгүй гэж үзэж байжээ.

⁶ Эдийн засагт илүүдэл эрэлт байсаар байхад үйлдвэрлэлийг дэмжих нэрийдлээр мөнгө, зээлийн бодлогыг хамаагүй сулруулах, тэр тусмаа үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын бүрэн төгс үзэл баримтлал боловсрогдоогүй, Засгийн газрын санхүүгийн чадвар сул байгаа нөхцөлд мөнгөний бодлогын жолоог хэтэрхий сул тавих нь гиперинфляцийн ирмэгт дахин тулж очих аюултай гэж тайлбарлаж байв.

Хэрэглэний үнийн индексээр тооцсон жилийн инфляци



Энэ үед “Алт дилерийн хэрэг” гэгч олон нийтэд ил болж, цочирдуулж байв. Монголбанкны валютын арилжааг шалгасан шинжээчдийн хийсэн тооцоогоор 1990-1992 онд нийт 92.6 сая ам.доллар (82.4 сая ам.долларын алдагдал+хэргийг шалгах хугацаанд нэмж бий болсон 20 гаруй сая ам.доллар)-ын алдагдал гарсан гэж тогтоож байжээ [2]. Өөрөөр хэлбэл, энэ дүнгээр гадаад валютын нөөц буурчээ. Энэ нь гадаад валютын нөөцийг удирдах, гадаад арилжаанд оролцох нь мэдээлэл авах сүлжээний өндөр хурд, өргөн хүрээний мэдлэг, туршлага шаарддаг гэдгийг анхааруулсан сургамж боллоо.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих дараагийн нэг томоохон алхам нь тогтмол ханшийн дэглэмийг халсан явдал байлаа. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1989 онд 3:1, 1990 онд 7:1, 1991 онд 15:1, 1992 онд 30:1 гэсэн харьцаатай байв. Улсын валютын нөөц шавхагдахын хэрээр ханшийг тогтвортой барихад хүндрэлтэй болсны дээр сэлбэг хэрэгсэл, материал, түүхий эд импортоор авах боломж хязгаарлагдаж эхэлжээ. Монголбанкны Ерөнхийлөгчийн 1993 оны тавдугаар сарын 27-ны өдрийн тушаалаар тогтмол ханшийн дэглэмээс валютын чөлөөтэй хөвөх ханшийн дэглэмд шилжив. Уг шийдвэрийн маргааш төгрөгийн гадаад валюттай харьцах чөлөөт Монголбанкны тогтолцоонд шилжих үеийн ханшийг 1 ам.доллар 393 төгрөгтэй тэнцэхээр тогтоожээ. Улмаар ОУВС-ийн “Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх хөтөлбөр”-ийг 1993 оны зургаадугаар сарын 25-наас 1996 оны зургаадугаар сарын 24-ний хооронд хэрэгжүүлэхээр тохиролцов.

Бодлогын томоохон өөрчлөлт хийгдсэнээр өмчийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмч хувьчлал хийгдэж, үнэ тарифыг чөлөөлж, валютын ханшийн чөлөөт тогтолцоонд шилжиж, гадаад худалдааны аливаа хоригийг цуцалж нээлттэй байхыг зарчмыг баримтлах болов. Гэхдээ эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх явцад манай эдийн засагт бий болсон нэг сөрөг үзэгдэл нь дотоод өр, авлагын тухай асуудал боллоо. Дотоод өр, авлагын хүндрэлтэй байдал нүүрлэж, үнэ, тариф, валютын ханшийг чөлөөлсөн нь аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлж, харилцан нэгэндээ төлж чадахгүй ихээхэн хэмжээний өр, авлагын гинжин хэлхээ үүсжээ.


Түүнчлэн банкны үйл ажиллагаанд олон төрлийн хязгаарлалт зонхилж байснаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хоорондын төлбөр тооцоо, хөрөнгийн солилцоонд бэлэн мөнгө зонхилох болж, улмаар 1992-1993 онд бэлэн мөнгөний хомстол бий болсон гэж үздэг. 1992 оны эцэс гэхэд Монголбанкны нөөцөд 100 сая төгрөгтэй тэнцэх бэлэн мөнгө үлдсэн байжээ. Төв банкнаас 1981 онд ЗХУ-д хэвлүүлсэн 1966 оны загварын мөнгөн тэмдэгтийн 20 жил хэрэглэхээр тооцсон нөөц ийнхүү 2-3 жилд гүйлгээнд гарч дууссан байна [2]. Түүнчлэн инфляци, валютын ханшийн сулралт нь мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийн хэмжээнд томоохон өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгов. Бэлэн мөнгөний хүрэлцээгүйгээс албан байгууллагууд цалин хөлсөө тавьж чадахгүйд хүрч, иргэдийн банкинд итгэх итгэл алдарч байв. Мөн төсвийн орлого тасарч, санхүүжилт саатан Засгийн газар төсвийн байгууллагуудын цалинг тасалдуулж, улмаар арилжааны

банкны төлөгдөхгүй болсноос болж, харилцагчийн мөнгийг цагт нь гарган өгч чадахгүйд хүрч байсан зэрэг эдийн засагт бий болсон хүндрэлийг иргэд бэлэн мөнгөний хомстолтой холбон ойлгож байв. Улмаар Монголбанк мөнгөний шинэ дэвсгэртийг бүтээлгэн, Улсын Бага Хуралд оруулснаар, мөнгөн тэмдэгтийн хэв загварыг 1922 оны тавдугаар сард баталж, шинэ мөнгөн дэвсгэртийг хэвлүүлж гүйлгээнд гаргажээ.

Төв банкны чиг үүргийг хэрэгжүүлж эхлэх, тэр дундаа мөнгө, зээлийн өсөлтийг хязгаарлах үүднээс мөнгөний бодлогын хэрэгслүүдийг 1991 оноос шинээр нэвтрүүлж эхэлжээ. Тухайлбал, 1992 оноос эхлэн төв банкинд арилжааны банкнуудын байршуулах заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тогтоон хэрэгжүүлж, 1994 оны байдлаар арилжааны банкнууд татан төвлөрүүлсэн хөрөнгийн 14 хувийг төв банкинд заавал байлгах нөөц хэлбэрээр байршуулж байжээ. Мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах шууд бус хэрэгсэл болох Төв банкны үнэт цаасыг 1993 оны сүүлээс гүйлгээнд гаргаж эхэлжээ (Зураг 8). Энэ нь нийт мөнгөний гүйлгээнд Монголбанкнаас тавих хяналтыг сайжруулах, үнийн өсөлтийг хязгаарлахад түлхэц болж, банкнуудыг зээлийн зохиомол эрэлтийн эрхшээлд автахас сэргийлэх, зээлийн нөөцийг зохистойгоор дахин хуваарилах боломжийг олгож эхэлжээ.

Зураг 8

Мөнгөний бодлогын арга, хэрэгслийн хөгжил



Эх сурвалж: Монголбанк

1993 оноос эдийн засгийн тогтворжуулах, шинэчлэлийн гол чиглэлийг хэрэгжүүлэх ажил Засгийн газраас ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн хүрээнд явагдаж байв [24]. 1993 оны төрийн мөнгөний бодлогын хүрээнд зээлийн хүүг инфляцийн түвшинтэй уялдуулан тогтоох, зээл болон хадгаламжийн хүүний түвшинг ойртуулж, иргэдийн банкин дахь хадгаламжийг үнэгүйдлээс хамгаалах, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг чөлөөт тогтолцоонд шилжүүлэх, арилжааны банкны заавал байлгах нөөцийн хувь хэмжээнд

өөрчлөлт оруулж, урамшил, хөшүүргийн системтэй болгох, зээлийн өрийн үлдэгдлийг багасгах, хөдөө аж ахуйн цаг үеийн ажлыг санхүүжүүлэхэд зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх, бэлэн мөнгөний хомстлыг багасгах зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Түүнчлэн ОУВС-тай тохиролцсон Стэнд-бай хөтөлбөрт тусгагдсан мөнгөн гүйлгээ, зээлийн үзүүлэлтүүдийн зорилтыг биелүүлж, дараагийн шатны хөтөлбөр болох “Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх хөтөлбөр”-ийн баримт бичигт мөнгөний бодлогын талаар харилцан хүлээх үзүүлэлтийг тохирсон байна. Монголбанкнаас арилжааны банкинд зээлийн өрийн үлдэгдлийн дээд хязгаар тогтоон өгч, зээлийн төлөлтөд хяналт тавьж байжээ [22].

Дотоодын үйлдвэрлэл сул, инфляци өндөр байсан тул арилжааны банкнууд өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цехийг шинээр байгуулах, өргөтгөхөд хөнгөлөлттэй хүүтэй зээл олгоход анхаарч байжээ. Банкнуудын холбоо 1992 онд байгуулагдаж, банкны боловсон хүчин бэлтгэх, банкны ажилчдын нийтлэг эрх ашгийн хамгаалах, төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилготой ажиллаж эхэлжээ. 1993 онд төлбөр тооцооны системийн талаарх ерөнхий бодлого, чиглэлийг тодорхойлж байх үүрэг бүхий “Үндэсний төлбөр зохицуулах зөвлөл”-ийг байгуулж, улмаар 1995 онд “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай” хууль батлагдсанаар бэлэн бус төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, вексель, төлбөрийн карт болон төлбөрийн бусад баримтаар гүйцэтгэх болжээ.

Хуучин улсын банк байх үед олгогдсон бөгөөд банкны хоёр шатлалтай тогтолцоо бүрдэх үед арилжааны банкинд шилжсэн 8.4 тэрбум төгрөгийн зээлээс 1993 оны долдугаар сарын 1-ний байдлаар 2.4 тэрбум төгрөгийн зээл (*нийт шилжсэн зээлийн 28.6 хувь*) эргэж төлөгдөх найдваргүй буюу эргэлзээтэй гэсэн урьдчилсан судалгаа гарч байжээ. Энэ найдваргүй зээлийн 53.2 хувь нь Худалдаа, хөгжлийн банк (ХХБ)-д, 25.4 хувь нь ХОТШ банкинд, 8.4 хувь нь Ардын банкинд, 8.2 хувь нь Үйлдвэрийн хувь нийлүүлсэн банкинд, 1.2 хувь нь Хөдөө аж ахуйн банкинд тус тус байжээ. Мөн банкны өөрийн үйл ажиллагаанаас шалтгаалж, дөрвөн арилжааны банкин дээр 170.8 сая төгрөгийн эргэж төлөгдөх найдваргүй зээл бий болсон байна. Тухайлбал, ХХБ-нд 47.8 хувь нь, 36.8 хувь нь ХОТШ банкинд, 14.9 хувь нь Ардын банкинд, 3.4 хувь нь Хөдөө аж ахуйн банкинд тус тус байжээ [22].

Түүнчлэн банкнуудад хийсэн шалгалтаар арилжааны банк янз бүрийн эх үүсвэрээс дүрмийн сан байгуулдаг, Монголбанкны зөвшөөрөлгүйгээр салбар нээж ажиллуулах, өөрийн эх үүсвэрээс хэтрүүлж зээл олгох, өөрийн актив, пассивыг оновчтой удирдаж чадахгүй байх, зээл олголтод тавих хяналт сул, олгосон зээлдээ тогтмол судалгаа, шинжилгээ хийх ажил хэвшил болоогүй, харилцагчийн анхны шаардлагаар төлбөрийн гүйлгээг хийж өгөхгүй байх, мөнгө, зээлийн бодлогын асуудлаар Монголбанкнаас гаргасан шийдвэрийг хагас дутуу биелүүлэх зэрэг зөрчил, дутагдал нийтлэг гарч байжээ.

1992 оны нэгдүгээр сарын 13-нд Ардын Их Хурлын чуулганаар Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталснаар 1993 оноос эхлэн дараа онд баримтлах төрийн мөнгөний бодлогыг УИХ-аас баталж эхэлсэн боловч тухайн үеийн эрх зүйн зохицуулалтаар төв банкны бие даасан байдал сул байжээ. Тухайлбал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс цаг үеийн ажилд хөнгөлөлттэй зээл олгож, зээлийн хүүгийн зөрөөг төсвөөс нөхөх арга хэмжээг төрийн мөнгөний бодлого, улсын төвлөрсөн төсөвт жил бүр тусгаж байхыг Засгийн газар, Монголбанкинд зөвлөмж болгож байжээ. Тухайн үед Монголбанк нь үйлдвэрлэлийг дэмжих мөнгөний бодлогыг явуулна, гэхдээ бүх асуудлыг зээлтэй холбож ойлгох нь өрөөсгөл гэж үзэж байв. Аж үйлдвэрийн салбарт бүтцийн өөрчлөлт үндсэндээ хийгдээгүй, үйлдвэрлэлт, борлуулалт, хангалтын шинэ тогтолцоо бүрэлдэж төлөвшөөгүй байгаа нь үйлдвэрлэлийг одоогийн түвшинд байлгахад ч хүндрэлтэй байж болзошгүй байгааг онцолж байжээ.

Ийнхүү шилжилтийн эхний үеийг давж, төв банкнаас арилжааны банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгох, тэдгээрийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх үзүүлэлт, бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем тогтоож, мөнгөний бодлогын чангатгах арга хэмжээ авч эхэлснээр Төв банкны зохицуулалтад арилжааны банкууд орж, банкны хоёр шатлал бүхий шинэ тогтолцоо нэлээд төлөвших хандлагатай болж, ажил нь зүгширч байна гэж дүгнэж байв. Моломжамц [23] инфляцийг бүрэн хяналтад авах, төгрөгийн худалдан авах чадварыг дээшлүүлэхийн тулд мөнгөний нийлүүлэлтийг зохион байгуулах, зээл, хадгаламжийн хүүний зохистой харьцааг бий болгох, заавал байлгах нөөцийг бодлогыг оновчтой хэрэгжүүлэх, үнэт цаасны хоёрдогч зах зээлийг зохион байгуулах, зээлийн салбар хоорондын тэнцлийг зохистой барих, зээл олголтод тавих хяналтыг хүчтэй болгох зэрэг нь төв банкны анхаарлын төвд байгааг онцолж байв. 1994 оны байдлаар арилжааны 15 банк ажиллаж байсны дотор Засгийн газрын банк 1, хувийн хэвшлийн банк 2, Монгол-Оросын хамтарсан банк 1, төрийн өмч оролцсон, хувь нийлүүлсэн 11 арилжааны банк ажиллаж байжээ. Арилжааны банкны 600 гаруй салбар, төв, орон нутагт байгуулагдаж, 5000 гаруй хүн ажиллаж, хөдөлмөрчид, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилж байв.


Харин 1994 оноос эдийн засгийн өсөлт эерэг түвшинд шилжихэд уул уурхай, хөдөө аж ахуй болон худалдаа үйлчилгээний салбарууд гол нөлөө үзүүлсэн бол боловсруулах салбар 1998 он хүртэл уналттай хэвээр байв. Ялангуяа 1994-1995 онд зэсийн үнийн өсөлтөөс үүдэлтэй уул уурхайн салбарын өрнөлийн эхлэл тавигдаж байв.

Гэвч 1994 оноос хуримтлагдсан хүндрэлүүд ил гарч, банкны салбарын хүндрэл эхлэв. Тухайлбал, 1994 оны есдүгээр сард Монгол хоршоо банкныг Ардын банкттай, Сэлэнгэ банкныг ХОТШ банкттай нэгтгэсэн нь банкны бүтцийн өөрчлөлт хийх анхны оролдлого байв. Мөн ММ инвест банкныг татан буулгасан бол 1995 оны гуравдугаар сард Их зам банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгож байсан [21] нь зөвхөн 1996-1999 онд үргэлжилсэн банкны хямралын суурь дохио байв.

Хэдийгээр 1996-2000 онд эдийн засгийн бодит секторт эерэг өөрчлөлт байсан хэдий ч дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ буурч, нам түвшинд хадгалагдаж, банкнуудын төлбөрийн чадвар муудаж, үйл ажиллагаа нь доголдож эхэлсэн нь эдийн засгийн ерөнхий идэвхжил сулрахад нөлөөлж байв. Инфляци 1996-1998 оны хооронд огцом буурч, нэг оронтой тоонд шилжиж, 2000 оны сүүл хүртэл харьцангуй нам түвшинд хадгалагджээ (Зураг 9).

Зураг 9

Монгол Улсад 1991 оноос хойш татан буугдсан банкны жагсаалт



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний хатуу бодлого, банкнуудын дампуурлаас шалтгаалан эдийн засгийн өсөлт эргэн саарч 2-3 хувьтай байв (Зураг 5). Инфляцийн хурдацтай бууралт нь аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд том цохилт болж зээлийн эргэн төлөлтөд ч тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлөв. Тухайлбал, өндөр хүүтэй зээл авч, үйл ажиллагаа эрхлэхэд бүтээгдэхүүний үнийн өсөлт бага байснаар тухайн аж ахуйн нэгжүүд алдагдал хүлээхэд хүрнэ.


УИХ-аас 1996 онд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийг баталж, мөнгөний бодлогын зорилгоор хэрэглэх хэрэгслүүдийн хүрээг тогтоон хуульчилж, энэ үеэс 1993 оноос хэрэглэж ирсэн ТБҮЦ-ны хэрэгслийг мөнгөний нийлүүлэлтийг хэмжээг тохируулан удирдах гол хэрэгсэл болгон ашиглаж иржээ. Банкнуудын хөрөнгийг удирдлагын үр ашгийг сайжруулах, банк хоорондын захын идэвхжлийг хангах зорилгоор овернайт зээл болон репо санхүүжилтийн хэрэгслийг 2001 оноос төв банкинд хэрэгсэл болгон ашиглаж эхэлжээ (Зураг 8).

1996 он гэхэд банкнаас хөрөнгө зугтах үзэгдэл газар авч, банкны хадгаламж 35 хувиар буурч байжээ. Төлбөрийн чадваргүй болж, алдагдал нь өссөөр байсан Монгол даатгал болон Ардын банкныг 1996 оны 12 дугаар сард татан буулгаж, улмаар тэдгээрийн хадгаламжийг шинээр байгуулагдсан Хадгаламж банкинд, бусад хэвийн хөрөнгийг Сүргээн босголтын банкинд шилжүүлжээ. Монгол Улс ОУВС-гийн Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх хөтөлбөрийн хоёр дахь шатыг 1997 оны зургаадугаар сарын 30-наас (2000 оны 6 дугаар сарын 29-ний хооронд 3 жилийн хугацаатай) хэрэгжүүлж эхэлжээ (Зураг 7). Энэ хөтөлбөрийн хугацаанд

зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үед борооны дараах мөөг мэт шинээр байгуулагдсан олон банк дампуурч, банкны салбар эрүүлжих алхам хийгджээ. Тухайлбал, 1998 онд Эдийн тэнгэр, Монголбизнес банк, 1999 онд Баянбогд, Азийн хөрөнгө оруулалтын банк, Сэргээн босголт, ХОТШ, Экспорт, импорт банк дампуурч байв (Зураг 9). Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь банкны хямралын үе шат буюу 1996 онд 50.8 хувь, 1999 онд 54.3 хувьд хүрчээ (Зураг 10).

Зураг 10

Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл (нийт зээлд эзлэх хувиар)



Эх сурвалж: Монголбанк

Ийнхүү Монгол Улс банкны хямралтай нүүр тулахад дараах хүчин зүйл нөлөөлжээ. Банкны хоёр шатлалт тогтолцоонд шилжээд удаагүй байсан тул төв банкны зүгээс банкнуудад тавих хяналт шалгалтын тогтолцоо гүйцэд бүрдээгүй, банкны удирдлагуудад банкны менежментийн талын мэдлэг дутмаг, төрийн мэдлийн банкнуудад тавигдах хяналт сул, арилжааны банкнуудын буруу менежмент, луйвар булхай зэрэг нь банкнуудыг ээлж дараалан дампуурахад хүргэж байв. Банкнуудын хувьд актив, зээлийн чанарын тухай ойлголт муу, зээлийн эрсдэлийг үнэлсэн судалгаа, шинжилгээ хийдэггүй, дотоод хяналтын тогтолцоо байхгүй, зээлдэгчдэд нь барьцаа хөрөнгөгүй зээлийн зөвхөн төслийн шинжилгээн дээр үндэслэн олгодог байсан зэрэг нөхцөлд үйл ажиллагаа явуулж байв. Үүний зэрэгцээ эдийн засагт гадаад, дотоод худалдааны орчин болон үнийн тогтолцоо гүйцэд бүрдээгүй, инфляци хэт өндөр, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тодорхой бус байдал өндөр байсан бөгөөд хууль, эрх зүйн хүрээнд зээлийг тойрсон эрх зүйн зохицуулалт бүрхэг, мөрдөгдөх ёстой цөөн тооны заавар журмын биелэлт тааруу байсан нь банкнуудын хувьд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл учруулж байв [21].

1997-1998 оны Азийн хямралын манай эдийн засагт үзүүлсэн шууд нөлөө сул байв. Тухайн үед гадаад орнуудтай санхүүгийн болон худалдааны хамаарал харьцангуй сул байсан нь үүнд нөлөөлсөн байна. Харин шууд бус нөлөө нь түүхий эдийн үнийн уналт, ОХУ-ын эдийн засгийн хямралаар дамжиж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралтад нөлөөлөв. Гадаад хүчин зүйл, банкны хямралаас үүдэлтэй дотоод эдийн засаг дахь долларжилтын нөлөөгөөр 1996-2000 оны хооронд төгрөгийн ам.доллартой харьцах ханш 58.8 хувиар суларчээ (Зураг 12).

4.2 Эдийн засгийн шилжилтийн дараах үе: 2000 оноос хойш

2000-2001 онд эдийн засгийн өсөлт саарахад ган, зуд болсноос хөдөө аж ахуйн салбар уналтад орсон нь голлон нөлөөлөв. Тухайн үед манай орны ядуурал өндөр буюу 36 хувьтай байсан тул Монгол улс 2001 оны есдүгээр сарын 28-ны өдөр ОУВС-ийн Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг гурав жилийн хугацаатай авч хэрэгжүүлсэн нь Монгол Улс ОУВС-гийн 4 дэх хөтөлбөрийг буюу 1991 оноос хойш байнга ОУВС-гийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй явдал байв (Зураг 6).


Алт, зэсийн үнэ 2001 оноос өсөж, банкны салбарын үйл ажиллагаа сэргэж, төрийн бодлогын тогтвортой байдал хадгалагдаж, худалдаа үйлчилгээний болон боловсруулах салбарууд сэргэснээр эдийн засаг 2001-2008 онуудад тогтвортой өсөж, өндөр түвшинд хадгалагдав. Тухайлбал, тухайн жилүүдэд жил бүр дунджаар 7.1 хувиар өсжээ (Зураг 5).

Энэ үед банкны салбар ч тогтвортой байв.⁷ 2001-2005 онд эдийн засагт мөнгөжилтийн процесс явагдсан гэж үздэг. Учир нь эдийн засгийн сэргэлтийг даган мөнгө, зээлийн үзүүлэлт хурдацтай өссөн хэдий ч инфляци нам түвшинд тогтвортой хадгалагдсан юм. Тухайлбал, тухайн жилүүдэд мөнгөний нийлүүлэлт жил бүр 20 хувиас, нийт зээл 40 хувиас өндөр өссөн хэдий ч инфляци нэг оронтой тоонд хадгалагдав (Зураг 11).

Харин 2004-2008 онд байгаль, цаг уурын тааламжтай нөхцөлтэй байсан бөгөөд уул уурхайн дараагийн хөөсрөлттэй тулгарлаа. Энэ хөөсрөлт нь “Бороо гоулд” компани алтны үндсэн орд ашиглаж эхэлсэн буюу 2004 оноос эхлэв. Тухайн орд ашиглалтад орсноор алтны олборлолт 74.6 хувиар нэмэгдэж, энэ нь 2004 оны эдийн засгийн өсөлт (10.6 хувь)-ийн 3.8 нэгж хувийг дангаар бүрдүүлж байв [5]. Голланд өвчний шинж тэмдэг ёсоор уул уурхайн салбарын өндөр өсөлтөөс гадна худалдаа, үйлчилгээний салбар хурдацтай, төсвийн орлого, түүнийг дагаж төсвийн зардал огцом нэмэгдлээ.

⁷ Интер банк 2006 онд татан буугдсан боловч салбарын хувьд нөлөө багатай, жижиг банк байсан тул санхүүгийн тогтвортой байдалд нөлөө үзүүлээгүй.

Зураг 11



Эх сурвалж: Монголбанк

Төсөв, мөнгөний мөчлөг дагасан буюу зөөлөн бодлого хэрэгжүүлсэн тул мөнгө, зээлийн өсөлт хэт өндөр байв. Жишээлбэл, 2007 онд M2 мөнгөний нийлүүлэлт 56.3 хувь, нийт зээл 68.1 хувиар өсөв. Төсвийн тэлэлт нь төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн өсөлтөөр дамжин инфляцид ирэх нөлөө хүчтэй байв. Ялангуяа, төрийн албан хаагчдын цалинг өсгөх сургаар бараа, бүтээгдэхүүний үнийг урьдчилан, эсвэл дагуулан өсгөх байдал хүчтэй ажиглагдаж байв. Үүний дүнд эдийн засгийн халалт бий болж, үүнтэй зэрэгцэн хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөж, улмаар инфляци 2007-2008 онд 34 хувьд хүрч байв (Зураг 7). Тухайн өрнөлийн үед гадаад валютын дотогшлох урсгал өндөр байсан хэдий ч гадаад валютын нөөцийг хангалттай түвшинд нэмэгдүүлэхээс илүүтэй төгрөгийн нэрлэсэн ханшийг тогтвортой барих, чангаруулах сонголтыг хийж байв (Зураг 12). Энэхүү өндөр инфляцид хариу үйлдэл үзүүлж мөнгөний бодлогыг бодлогын хүүг өсгөх, заавал байлгах нөөцийн хувийг өсгөх зэргээр чангаруулах алхмыг хийсэн боловч 7 жил хуримтлуулсан хөөсийг богино хугацаанд эргүүлэх шимэх боломж хомс байсан тул хангалттай үр дүнтэй байгаагүй.

Эдийн засгийн ид өрнөлийн үед буюу 2006 онд хадгаламж, зээлийн хоршооны хямралтай нүүр тулав. Гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулга болон дотоод эх үүсвэрээс хуримтлал ихээр бий болж эхэлсэн үед хадгаламж, зээлийн хоршоод олноор байгуулагдаж, өндөр хүү амлах замаар их хэмжээний эх үүсвэр бүрдүүлэв. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд тавих төрийн зохицуулалт, хяналт сул байсны улмаас хоршоодын эзэд тухайн эх үүсвэрийг зүй бусаар зарцуулж, эцэстээ дампуурснаас олон иргэд хохирсон үйл явдал Санхүүгийн зохицуулах хороо шинээр байгуулагдсанаас хойш нэг жил

хүрэхгүй хугацааны дараа тохиолдсон нь санхүүгийн байгууллага дахь төрийн зохицуулалт, хяналт ямар чухал болохыг сануулсан сургамж байлаа.

Мөнгө, зээлийн өсөлт өндөр байсан жилүүдэд инфляци харьцангуй нам түвшинд байсан нь либералчлалын нөлөөгөөр мөнгө, инфляцийн хоорондын хамаарал манай эдийн засагт суларсныг илтгэж байв. Өөрөөр хэлбэл, мөнгөний үзүүлэлтийг онилох явцад мөнгөний эргэлтийн хурд, мөнгөний эрэлт, мөнгөний үржүүлэгч тогтворгүй болж, мөнгөний өсөлтийг хянах замаар инфляцийг хянах боломжгүй болов. Нөгөө талаас ТБҮЦ-ны хэмжээгээр дамжуулж, мөнгөний нийлүүлэлтийг хянах нөлөө сулраад байв. Иймээс 2007 оноос эхлэн мөнгөний бодлогын шинэ арга хэлбэрт аажмаар шилжих бэлтгэл ажлыг эхлүүлэв [9]. Олон улсын нийтлэг туршлага, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан инфляцийг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрт шилжих бэлтгэл ажлыг эхлүүлэв. Энэхүү шинэ арга хэлбэрт шилжихэд бодлогын үйл ажиллагааны зорилтыг банкны хоорондын захын хүү байхаар өөрчлөх, бодлогын нөлөөллийн шинжилгээ болон төсөөлөл хийх чадавхыг хөгжүүлэх шаардлагатай байв. Мөнгөний бодлогын арга хэрэгслийг боловсронгуй болгох ажлыг 2007 онд ОУВС-гийн техникийн тусламжтайгаар хийж эхлүүлэв. Энэ хүрээнд мөнгөний бодлогын хүүг⁸ бодлогын үндсэн хэрэгсэл болгон зарлаж, ТБҮЦ, Заавал байлгах нөөцийн журмыг шинэчилж, бодлогын хэрэгслийн нөлөөллийг сайжруулах зохицуулалтуудыг тусгав. Бодлогын шинжилгээ, төсөөлөл хийх чадавхаа сайжруулахад шаардлагатай арга хэмжээг мөн давхар авч хэрэгжүүллээ. Тухайлбал, анхны макро эдийн засгийн бүтцийн загвар болох SIMOM загварыг хөгжүүлэх ажлыг Польшийн Үндэсний банкны тусламжтайгаар 2006 оноос эхлүүлж, 2007 оноос ашиглаж эхлэв. Монголбанк “Төсөөлөл, бодлогын шинжилгээний систем”-ийг 2012-2016 оны хооронд амжилттай нутагшуулж, мөнгөний бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай бодлогын шинжилгээний чадавхыг хөгжүүлж, түүнээс хойш ашиглаж байна.


Энэхүү эдийн засгийн хөөсрөлт 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр эргэн хагарч 2009 онд эдийн засаг -1.3 хувиар уналаа (Зураг 5). Дэлхийн хямралын дотоод эдийн засагт шилжсэн суваг нь санхүүгийн холбоосноос илүүтэй гадаад худалдааны сувгаар буюу экспортын бүтээгдэхүүний үнийн уналтаар голлон дамжив. Экспортын бүтээгдэхүүний үнэ 2008 онд огцом буурч, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), гадаадад амьдарч буй монголчуудын мөнгөний гуйвуулгын хэмжээ татарч, хөрөнгийн гадагшлах урсгал ажиглагдсанаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт нэмэгдэв. Ханшийн сулрах дарамтыг сулруулах зорилготой валютын интервенци хийх замаар төгрөгийн эх үүсвэрийг эргүүлэн татах нөлөө хүчтэй байв. Үүний зэрэгцээ гадны байгууллагууд манай улсын банк,

⁸ Нөөц мөнгө буюу мөнгөний биет хэмжээг үйл ажиллагааны зорилт болгох боломжгүй болсон тул хүүний түвшинг ашиглан бодлого хэрэгжүүлэх шийдвэрийг 2007 оны долдугаар сарын 4-ний өдөр гаргаж, тухайн үед бодлогын гол хэрэгсэл болж байсан 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны хүүг бодлогын хүүгээр сонгов. Харин хүүний корридорын тогтолцоог хожим буюу 2012 онд нэвтрүүлээ.

санхүүгийн байгууллага, компаниудад өгсөн зээлээ эргүүлэн татаж, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хугацаагаа хойшлуулсан зэргээс дотоодын банкны салбарт зээлийн тасалдал үүсэж байв. Тухайлбал, М2 мөнгө 2008 онд 5.6 хувиар буурсан бол 2009 онд нийт зээлийн өсөлт 0.7 хувь байв (Зураг 11).

Зураг 12

Төгрөгийн нэрлэсэн ханш болон гадаад валютын цэвэр албан нөөц



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханшийн сулрах дарамт эхэлсэн үед тус сулралтыг зөвшөөрөхөөс илүүтэй гадаад валютын захад интервенци хийж, ханшийг хүчээр чангаруулж валютын ханшийн гажилтыг илт нэмэгдүүлсэн. Үүний дүнд гадаад валютын нөөц буурч, гадаад шокийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр төв банк нөөцөө шавхахад хүрсэн тул валютын захад оролцох оролцоогоо хязгаарласан. Улмаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2008 оны 8 дугаар сараас 2009 оны 3 дугаар сарын хооронд 37 хувиар суларсан (Зураг 12). Гэхдээ энэ удаагийн валютын нөөцийг шавхаж буй болгоомжлол 2014-2016 оны нөхцөл байдалтай харьцуулахад дөнгүүр байв.

Сөрөг хүчтэй гадаад шокуудын нөлөөгөөр төсвийн орлого огцом буурахтай зэрэгцэн төв банк ам.доллар зах зээлд нийлүүлж, эдийн засаг дахь төгрөгийн эх үүсвэрийг эргүүлэн татсанаар мөнгө, зээлийн өсөлт хурдацтай агшсаны нөлөөгөөр эдийн засаг 2009 онд уналтад орж, дефляцийг дагуулсан хэдий ч, энэ нь ердөө гурван сар (2009 оны 8 дугаар сараас 10 дугаар сарын хооронд) л үргэлжлэв.

Эдийн засгийн уналт бий болж, бизнес эрхлэгчдийн борлуулалт удааширч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан зэргээс зээлийн эрсдэл өсөж, чанаргүй зээл нэмэгдсэнээр банкны салбар 2008-2009 онд алдагдалтай ажилласан юм. Эдгээр нөхцөл байдал банкны салбарт хүндээр тусч улмаар 2008-2009 онд Анод банк ХК, Зоос банк ХК-ийн төлбөрийн чадвар муудан, үйл ажиллагаа нь доголдон дампуурлаа. Засгийн газраас Зоос банкны сайн актив дээр тулгуурлан бонд гарган Төрийн банкныг шинээр байгуулсан бөгөөд муу активыг Зоос банк ХК-д нь үлдээн өр төлбөрийг барагдуулах үүрэг бүхий Монголбанкны бүрэн эрхт төлөөлөгч, эрх хүлээн авагчийн зөвлөлийг ажиллуулав. Эдгээр нь банкны системд томоохонд тооцогдож байсан, эдгээр банкны дампууралтай үүдэлтэй гарсан зардал өндөр байсан тул ОУВС-гийн системийн шинж чанартай банкны хямралын 1970-2011 оны өгөгдлийн санд Монголд банкны хямрал 2008 онд эхэлж, 2009 оноос системийн шинжтэй болсон гэж бүртгэгджээ [20].

Энэхүү хямралт нөхцөл байдлыг хохирол багатай даван туулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар ОУВС-гийн Стэнд-бай хөтөлбөрийг 2009 оны гуравдугаар сард 18 сарын хугацаатай авч, амжилттай хэрэгжүүлэв. Энэ хөтөлбөрийн хүрээнд төсвийн дүрмийг хуульчилсан нь манай орны хувьд оновчтой макро бодлогыг хэрэгжүүлэх суурийг бүрдүүлсэн явдал байв. Гэхдээ Монголчууд азтай байж, эдийн засгийн энэ удаагийн хямрал бусад орнуудтай харьцуулахад удаан үргэлжлээгүй. Учир нь 2009 оны хоёрдугаар улирлаас эхлэн алт, зэсийн үнэ эргэн хурдацтай өсөж эхэлсэн бөгөөд дэлхийн хэмжээний том төсөл болох Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээг 2009 оны 10 дугаар сард байгуулж, тус төслийн эхний шатны хөрөнгө оруулалт 2010 оноос орж ирж эхлэв. Түүнчлэн 2011 оноос манай орноос Хятад руу гаргасан нүүрсний экспортын орлого огцом нэмэгдэв. Дэлхийн зах зээл дээр манай уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд байсан тул Оюу толгойн хөрөнгө оруулалтаас гадна уул уурхайн салбарт их хэмжээний ГШХО орж ирж байв.

Эдгээрийн дүнд төлбөрийн тэнцлийн дарамт буурсан нь глобал зах зээл дээрх түүхий эдийн үнийн супер циклийн Монгол дахь нөлөөллийн эхлэл байв.


Энэ үед төв банк орж ирсэн гадаад валютыг худалдан авах замаар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлсэн хэдий ч гадаад валют худалдан авах интервенци нь хангалттай байгаагүйгээс төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эргэн чангарч 2011 оны эхэн гэхэд 2007-2008 оны түвшинд эргэн хүрч байв. Тухайн үед уул уурхайн том ордуудад түшиглэн гадаад валютын урсгал нэмэгдэх тул төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт давамгайлж байсан тул төв банк орон урсгалыг бүрэн интервенцийн аргаар захаас татаж аваагүй, мөн валют худалдан авч төгрөг нийлүүлэх нь инфляцийг өдөөх эрсдэлтэй гэж харж байснаар ч тайлбарлагдана.

Ийнхүү уул уурхайн экспортын хэмжээ, валютын дотогшлох урсгал нэмэгдэж, эдийн засаг сэргэснээр 2010-2012 оны төсвийн орлого хурдацтай өсөж байв. Харамсалтай нь энэ үеийн уул уурхайн хөөсрөлтөөс бий болсон орлогоос ирээдүйд бий болж болзошгүй хүндрэлээс хамгаалах нөөц хөрөнгийг бүрдүүлж чадаагүй. Ялангуяа 2008 оны сонгуулиар хүчээ авсан бэлэн мөнгө тараах улс төрийн амлалт нь төсвийн орлогыг хэт хавтгайруулан зарцуулж, төсвийн нөөц хөрөнгө бүрдүүлэхгүй байх гол хүчин зүйл болов. Энэ амлалтыг 2011 оноос эхлэн Хүний хөгжлийн санд хуримтлуулсан хөрөнгөөс бэлэн мөнгө тараах хэлбэрээр хэрэгжүүлснээр төсөв богино хугацаанд хүчтэй тэлэв. Үүнд шаардлагатай нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэхийн тулд “Эрдэнэс таван толгой” компанийн ирээдүйд олборлох нүүрсийг барьцаалан 350 сая ам.долларын зээл авчээ. Энэхүү зээлийн нүүрсний экспортоор төлөх эргэн төлөлт 6 гаруй жил үргэлжилж 2017 оны 3 дугаар сард төлөгдөж дууссан билээ. Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд тус компанийн зээл өгсөн компанид нүүрсний экспорт хийсэн хэдий ч экспортын орлого орж ирэхгүй тухайн зээлийн үндсэн болон хүүний төлбөрийг төлөхөд зарцуулагдаж байв.

Ийнхүү хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэж, төсвийн тэлэлт үргэлжилж, эдгээрийн дүнд мөнгө, зээлийн өсөлт 2010-2011 онд 60-70 хувиар өсөв. Өөрөөр хэлбэл, төсөв, мөнгөний бодлогын хувьд мөн л мөчлөг дагасан хэлбэрээр хэрэгжсэн. Эдийн засгийн ийм орчинд инфляци эргэн хурдацтай өсөж 2010 онд инфляци хоёр оронтой тоонд шилжив. Харин эдийн засгийн өсөлт 2011 онд 17.5 хувьд хүрч бүс нутагтаа төдийгүй дэлхий (Азербайжаны хамт)-д өндөр өсөлтөөр тэргүүлэв. Гэхдээ уул уурхайгаас хамааралтай манай эдийн засгийн хувьд энэ рекорд нь удаан үргэлжлээгүй бөгөөд эргээд эдийн засгийн мөчлөгийн уналтын хэсэг рүү шилжиж эхлэв.

Шилжилтийн эдийн засгийн арван жилд банкны салбарын үүсэл, дараа нь хямрал байсаар өргөжилт ажиглагдаагүй бол 2000 оноос хойш тогтвортой өргөжилт гарч байна (Зураг 13).

Зураг 13



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын санхүүгийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг илтгэх үзүүлэлтүүд 2004 оноос хойш тогтмол сайжирч ирлээ (Зураг 14). Тухайлбал, арилжааны банк дахь данс эзэмшигчдийн өсөлттэй явж ирсэн бөгөөд 2012 оноос хойш банкны салбарын тоо тогтвортой байж, харин санхүүгийн үйлчилгээг АТМ-ээр хүргэх байдал илт нэмэгджээ.

Зураг 14



Эх сурвалж: Монголбанк

Сонгуулийн бусад жилийн адил 2012 оны сонгуулийн өмнө төсвийн тэлэлт нэмэгдэж, инфляцийг өдөөсөн бөгөөд тухайн үеийн инфляцид эрэлтээс гадна нийлүүлэлтийн хүчин зүйлийн нөлөө хүчтэй байв. Ялангуяа дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өсөж байсан тул дотоодын шатахууны үнэ өссөн бөгөөд мах болон бусад хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт ч өндөр байв. Оюу толгой төслийн эхний шатны хөрөнгө оруулалтын ажил дуусах шатандаа орж байсан тул түүнийг дагасан ГШХО 2012 оноос буурч байв. Түүнчлэн 2012 оны тавдугаар сард “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль батлагдсанаар эрдэс баялаг, банк, санхүү болон хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарыг стратегийн салбар гэж үзэн эдгээр салбарт хийх ГШХО хийх үйл ажиллагааг харьцангуй түвэгтэй болгосны дээр, тус хуулийг хэрэгжүүлэх журмууд хугацаа оройтож гарсан нь ГШХО буурч эхлэх хүчин зүйл болсон гэж үздэг. Үүний зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ 2012 оноос буурч эхэлсэн нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулав. Ийнхүү экспортын бүтээгдэхүүний үнэ буурч, ГШХО огцом унасан нь төлбөрийн тэнцлийн дарамтыг нэмэгдүүлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамтыг бий болгож эхлэв.

2012 оны зургаадугаар сард болсон УИХ-ын сонгуулиар Ардчилсан нам, шинээр байгуулагдсан Монгол Ардын хувьсгалт намын хамтарсан эвсэл төрийн эрхэнд гарч, шинэ Засгийн газар бүрэлдсэнээр бодлогын өөрчлөлтүүд гарлаа. Монголбанкны 2012 оны сүүлийн улирлаас эхлэн эдийн засгийн дэмжих зорилгоор уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд зах зээлийн өртгөөс хямд хүүтэй санхүүжилтийг эдийн засгийн тодорхой салбаруудад нийлүүлэх бодлого хэрэгжүүлээ.⁹ KPMG [19]-ийн тайланд дурдсанаар 2012-2016 онд Монголбанк нийт 7.2 их наяд төгрөг (*дундаж ханшаар тооцоход 3.9 тэрбум ам.доллар, ДНБ-ий 32.6 хувьтай тэнцэх*)-ийн санхүүжилтийг төсвийн шинж чанартай үйл ажиллагааг санхүүжүүлэхэд олгожээ.

Түүнчлэн түүхий эдийн үнийн супер мөчлөгийн төгсгөл үе буюу 2012 оны сүүлээр манай орны зээлжих зэрэглэл өндөр, макро үзүүлэлтүүд сайн байсан тул гадаад зах зээл дээр бонд гаргах тохиолдолд хүү нь бага байхаар байв. Иймд 2012 оны арванхоёрдугаар сард 1.5 ам.долларын Чингис бондыг олон улсын зах зээл дээр гаргав. Энэхүү бондын мөнгөн хөрөнгө манайд орж ирснээр Монгол

⁹ Тухайлбал, эдийн засгийн идэвхжил суларч, мөнгө, зээлийн өсөлт саарч, нөгөө талд инфляци нь мах, шатахууны үнийн өсөлтөөр өдөөгдөж байсан тул Засгийн газар, Төв банктай хамтран “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэв. Тус хөтөлбөрийн хүрээнд Төв банкнаас хөнгөлөлттэй зээлийг банкнуудаар дамжуулан аж ахуйн нэгж, иргэдэд шууд олголоо. Эдгээр хөтөлбөрөөс хамгийн том өртөгтэй нь 8 хувийн ипотекийн зээлийн хөтөлбөр байв. Мах, гурил болон шатахууны дэд хөтөлбөр нь агуулахад суурилсан санхүүжилтийн схемд суурилан нөөц бүрдүүлэх замаар үнийн хэлбэлзлээс хамгаалах гэсэн үндсэн санааг агуулж байв. Харин 8 хувийн ипотекийн зээлийн хөтөлбөр нь иргэдийн орон байртай болох хэрэгцээ, шаардлага, нөгөө талдаа институциональ хөрөнгө оруулагчийг бий болгох, ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх үндсэн санаан дээр суурилжээ. Энэхүү хөтөлбөрөөс гадна бусад олон төрлийн төсвийн шинж чанартай үйл ажиллагааг Монголбанк санхүүжүүлжээ.

Улсын гадаад валютын нөөцийн хэмжээ 4 тэрбум ам.долларт хүрч нэмэгдэв. Чингис бондын зарцуулалт, төв банкны төсвийн шинж чанартай арга хэмжээний дүнд мөнгө, зээлийн үзүүлэлтүүд эргэж өндөр хувиар өсөж, эдийн засгийн өсөлт түр хугацаанд өндөр түвшинд хадгалагдсан юм. Өөрөөр хэлбэл, эдийн засаг 2012 онд 12.4 хувь, 2013 онд 11.7 хувиар өслөө (Зураг 5). Харин эдийн засгийн энэхүү түр хугацааны сэргэлт нь эрэлтийн шалтгаантай инфляцийг бий болгож, инфляци 2013-2014 онд эргэн өсөж хоёр оронтой тоон шилжихэд хүргэлээ (Зураг 6). Учир нь үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр нийлүүлэлтийн шалтгааны инфляци түр хугацаанд харьцангуй бага байлаа.

Тухайн үед хувь нийлүүлэгчтэй холбоотой чанаргүй зээлээс шалтгаалан өөрийн хөрөнгө нь алдагдсан Хадгаламж банкны зарим актив, пассив хөрөнгийг Төрийн банкинд шилжүүлэх үйл ажиллагааг 2013 он долдугаар сард хэрэгжүүлж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагааг эхлүүлээ. Эдийн засгийн нөхцөл байдалтай хамааралгүй буюу Голомт банкны хувь эзэмшигчдийн хоорондын маргаан 2013 оноос хойш олон нийтэд нээлттэй болж, үргэлжилсээр 2015 онд Голомт, Богд банк болж салжээ.

Сөрөггадаадшоктой орчинд эдийн засгийг дэмжих зорилгоор хэрэгжүүлсэн төсвийн болон төв банкны төсвийн шинж чанартай бодлогын арга хэмжээний эерэг нөлөө тийм удаан үргэлжлээгүй. Аж ахуйн нэгж, иргэд төгрөгөөр авсан зээлээ гадаад валют руу хөрвүүлэн импортын төлбөрт шилжүүлж байв. Түүнчлэн төв банк, хөгжлийн банкны санхүүжилт болон төсвийн зарцуулалтын 100 төгрөг тутмын 50 төгрөг нь импортын төлбөрт гарч байсан тооцоо бий. Иймд импорт богино хугацаанд хүчтэй өсөж, урсгал тэнцэл маш том алдагдалтай гарч байв. Улмаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт нэмэгдэж байв.

Иймд төв банк валютын нөөцөөс гадаад валютын захад интервенци хийснээр валютын нөөц эргэн хурдацтай буурч эхлэв. Валютын нөөц үргэлжлэн буурч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт хэвээр байсан тул олон улсын зах зээл дээр бонд арилжаалах, зээл авахад Засгийн газар, төв банк онцгой анхаарч улсын гадаад өрийн хэмжээ үргэлжлэн өссөн. Өөрөөр хэлбэл, дотоод хэрэглээний тэлэлтээр өдөөгдсөн урсгал тэнцлийн алдагдлыг гадаад зээлээр санхүүжүүлж байв. Эдийн засаг дахь мөнгөний өсөлтийн инерци суларч, шинээр гарах санхүүжилт буурснаар зээлийн өсөлт эргэн саарч эхлэв. Энэ нь эдийн засгийн өсөлт 2015 оноос саарахад нөлөөлөв. Гадаад зээлээр санхүүжсэн төсвийн тэлэлт, төв банкнаас гарах санхүүжилт үргэлжилж байснаас үүдэлтэй валютын ханшийн сулрах дарамт (*нөгөө талдаа эдийн засаг дахь гадаад валютын өндөр эрэлтийг хангахын тулд*)-ыг валютын нөөцөөр интервенциэр тогтоосоор байв. Валютын нөөц буурахын хэрээр төв банк арилжааны банкнуудад төгрөг өгч ам.доллар авах том дүнтэй, урт хугацааны гадаад валютын своп хэлцэл хийж, интервенци хийх гадаад валютын нөөцийг бүрдүүлэв. Үүний зэрэгцээ БНХАУ-ын Ардын банкт байгуулсан мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хүрээнд их хэмжээний юань татаж, валютын интервенцийн зорилгоор ашиглав. Үүний дүнд Монгол Улсын гадаад валютын

цэвэр албан нөөцийн хэмжээ 2014 оны сүүлээс хойш сөрөг түвшинд шилжиж, сөрөг дүнгээр өссөн (Зураг 12). Өөрөөр хэлбэл, төв банкны гадаад валютын өр төлбөрийн хэмжээ активаас давж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах тохиолдолд төв банкны алдагдал өсөх нөхцөл байдал руу шилжлээ.

Өөр нэг асуудал нь төв банк нэг талаас төгрөгийн эх үүсвэрийг төсвийн шинж чанартай үйл ажиллагааны хүрээнд олгож байсан хэдий ч нөгөө талаас валютын интервенци хийх замаар тухайн төгрөгийг эргүүлэн татан авч байв. Ялангуяа интервенци илүү идэвхтэй байсан үед мөнгөний нийлүүлэлт огцом өсөхгүй эсвэл мөнгө нийлүүлсээр байсан үед ч мөнгө, зээлийн өсөлт саарч байсан нь үүгээр тайлбарлагдана.

Гадаад сөрөг шок даамжирч, ГШХО зогсож, гадаад валютын нөөц шавхагдаж, улмаар мөнгө, зээлийн өсөлт сөрөг түвшинд хүрснээр эдийн засгийн өсөлт 2015 оноос үргэлжлэн огцом саарсан боловч эдийн засгийн өсөлт эерэг түвшинд байхад Оюу толгой төслийн олборлолт 2013 оноос эхэлсэн нь голлон нөлөөлсөн байна. Эдийн засгийн идэвхжил сулрахын хэрээр инфляци даган буурч байв. Инфляци ийнхүү буурахад 8 хувийн ипотекийн зээлийн хөтөлбөр ч тодорхой сувгаар нөлөөлсөн байх боломжтой. Өрх гэрүүд тухайн зээлд өргөнөөр хамрагдаж, өрхүүдийн зээл нийт зээлийн 40 хувь, ДНБ-ий 25 хувь хүртэл өссөн. Ингэснээр өрхүүдийн зээлийн хүүний төлбөрөө төлөх дарамт нэмэгдсэн нь бусад хэрэглээний зардлыг хязгаарлахад хүргэж, ялангуяа эдийн засгийн өсөлт саарч буй он жилүүдэд өрхийн хэрэглээ илүү ихээр хумигдахад нөлөөлжээ.

Эдийн засгийн нөхцөл байдал суларснаар 2015 оны сүүлийн хагасаас ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах эсэх асуудал яригдаж, Засгийн газрын зүгээс ОУВС-гийн ажлын хэсгийг ирж ажиллахыг урьжээ. Гэхдээ эрх баригчид тухайн хөтөлбөрийг авах нь цаг хугацааны хувьд зохистой гэдэг дээр нэгдсэн байр сууринд хүрээгүй тул хөтөлбөр авахгүй байхаар шийдэж, улмаар 2016 оны сонгуультай золгов.

Сонгуулийн бусад жилийн адил 2016 оны сонгуулийн өмнө эрх баригчид гадаад зах зээлд бонд гаргах, зээл авах хэлбэрээр эх үүсвэрийг гаднаас авчирч мөн л олон төрлийн “Сайн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, төсвийн зардлыг өсгөж, улмаар Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлсэн. Зөвхөн Засгийн газрын өрийн хэмжээ гэхэд л 2011 онд ДНБ-ий 42 орчим хувь байсан бол 2016 оны эцсийн байдлаар 80 орчим хувьд хүрээд байв. Үүний зэрэгцээ сонгуулийн өмнө Монгол зэс корпораци Оросын талын эзэмшиж байсан Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг худалдан авч, дотоодын зах зээлээс валютын нөөцийн 30 орчим хувьтай тэнцэх хэмжээний валютын урсгал гадагшилжээ.

УИХ-ын 2016 оны ээлжит сонгуулиар Монгол ардын нам төрийн эрхэнд гарч, шинээр байгуулагдсан Засгийн газар өмнөх жилүүдэд хэрэгжсэн тэлэх бодлогын нөлөөгөөр төсвийн бодит алдагдал, Засгийн газрын өр болон гадаад валютын цэвэр нөөц ямар түвшинд хүрснийг нийтэд мэдээлэв. Сонгуулийн өмнөх том шок, сонгуулийн дараах эдгээр бодит нөхцөл байдлын талаарх статистик мэдээлэл нь дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, зэрэглэл тогтоогч

байгууллагуудад цочрол болов. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2016 оны долдугаар сараас огцом суларч, иргэд мөнгөн хөрөнгөө гадаад валют руу хөрвүүлж, Хөгжлийн банкны олон улсын зах зээл дээр гаргасан бондын үнэ огцом буурч, зээлжих зэрэглэлийн агентлагууд 2016 оны есдүгээр сараас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулж эхэлсэн билээ. Зээлжих зэрэглэл буурч, гадаад зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх өртөг нэмэгдсэн, хөрөнгө оруулагчид эдийн засгийн цаашдын төлөвт итгэх итгэл суларсан нь гадаад зах зээлээс эх үүсвэр, хөрөнгө оруулалт татах боломжийг бүрэн хязгаарлаж, өндөр хүүтэй эх үүсвэр нь өрийн тогтворгүй байдлыг улам эрчимжүүлэхэд хүргэхээр байлаа.

Эдийн засгийн суурь нөхцөл байдал суларсаар ирсэн үед эдгээр сөрөг өөрчлөлт нь маш хүндээр тусав. Төв банкны зүгээс төгрөгийн үнэ цэнийг хамгаалах зорилгоор бодлогын хүүг 2016 оны наймдугаар сард 4.5 нэгж хувиар өсгөж, 15 хувьд хүргэсэн дунд хугацааны өрийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийг тогтворжуулахын тулд Монгол Улсын Засгийн газар ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг гурван жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр болов. Энэхүү хөтөлбөрт орох шийдвэр нь эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөвт бүрэн хэмжээний дүн шинжилгээ хийсний үндсэн дээр үндэсний эрх ашиг, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нийтлэг эрх ашгийн харгалзан авч хэрэгжүүлсэн арга хэмжээ гэдгийг энд онцлох нь зүйтэй.

2016 оны гуравдугаар улирлын байдлаар эдийн засгийн өсөлт сөрөг түвшинд хүрч, дефляци ажиглагдаж, банкны салбарт эрсдэл хуримтлагдаж, ОУВС-гийн тодорхойлолтоор гадаад валютын цэвэр нөөц -2.75 тэрбум ам.долларт хүрч¹⁰, улсын гадаад өрийн том дүнтэй эргэн төлөлт шилээ даран хүлээгдэж байлаа. Ялангуяа, төсвийн болон гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, өрийн дефолтоос зайлсхийх асуудал том сорилт болж байлаа. Тухайлбал, Хөгжлийн банкны 580 сая ам.долларын эргэн төлөлт 2017 оны гуравдугаар сард, БНХАУ-ын Ардын банк болон Монголбанкны хооронд байгуулсан төгрөг, юанийн своп хэлцлээр Монголын талын авч ашигласан 12 тэрбум юанийн эргэн төлөлт 2017 оны наймдугаар сараас эхлэх, Чингис бондын 500 сая ам.долларын эргэн төлөлт 2018 оны нэгдүгээр сард, Димсам бондын 1 тэрбум юань (*160 орчим сая ам.доллар*)-ий эргэн төлөлт 2018 оны зургаадугаар сард хийгдэхээр шилээ даран хүлээгдэж байлаа. Эдгээр өр төлбөрийг төлөхөд гадаад валютын нөөц хүрэлцэхгүй, валютын дотоодын зах зээл дээр ноцтой хүндрэл бий болгохоор байсан тул өрийг төлөхөд гадаад зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх, дахин санхүүжүүлэх зайлшгүй шаардлагатай байв. Гэхдээ эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, бодлогын сахилга бат алдагдаад байсан тул гадаад зах зээл дээр дахин санхүүжилт хийхэд эрэлт бага байх, хүү нь өндөр байж дунд хугацааны өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй байв. Иймд гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, доноруудын хөнгөлөлттэй нөхцөл (*урт хугацаатай, хямд хүүтэй*)-тэй санхүүжилтээр төсвийн болон төлбөрийн тэнцлийн хүндрэлийг даван туулж, эдийн засгийг богино хугацаанд сэргээх,

¹⁰ Тухайн үед мөрдөгдөж байсан Монголбанкны тодорхойлолтоор гадаад валютын цэвэр нөөц -402 сая ам.доллар байлаа.

эдийн засаг, санхүүгийн салбарт зайлшгүй шаардлагатай байсан реформуудыг богино хугацаанд хийх үүднээс ОУВС-гийн хөтөлбөрт орох шаардлагатай байв. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлж, доноруудаас санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болсон мэдээ нь хөрөнгө оруулагчдын Монгол Улсын эдийн засгийн төлөвт итгэх итгэлийг сэргээж, хугацаа нь дуусахаар хүлээгдэж байсан Хөгжлийн банк, Засгийн газрын бондуудыг амжилттай дахин санхүүжүүлж, 2017 оны наймдугаар сарын 21-нд хугацаа нь дуусахаар хүлээгдэж байсан БНХАУ-ын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн хугацааг гурван жилээр сунгахаар болж богино хугацааны өрийн дарамт буурлаа.

Сүүлийн хоёр жил гаруй хугацаанд эдийн засгийн сэргэлт эрчимжиж (*эдийн засаг 2017 онд 5.3 хувиар, 2018 онд 6.9 хувиар өслөө*), инфляци зорилтот түвшний орчинд байж, эдийн засгийн дархлаа нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулагчдын Монголын эдийн засагт итгэх итгэл сэргэж, улмаар дефолтын эрсдэлээс зайлсхийж, хөтөлбөрийн хүрээнд тохирсон зорилтуудаа амжилттай ханган хэрэгжүүлж байна.

2016 оны долдугаар сард гадаад валютын албан нөөц 1.2 тэрбум ам.доллар, гадаад валютын цэвэр нөөц -2.75 тэрбум ам.долларт хүрсэн байлаа. Гадаад валютын нөөц ийнхүү буурч, цэвэр дүнгээр сөрөг өндөр түвшинд хүрсэн, 2016 оны зургаадугаар сард их хэмжээ (*400 орчим сая ам.доллар*)-ний гадаад валют дотоодын зах зээлээс гарсан, төсвийн болон төлбөрийн тэнцлийн олон жилийн алдагдал гүнзгийрсэн, нөгөө талдаа өндөр дүнтэй гадаад өр төлбөр хүлээгдэж байсан нь валютын захад оролцогчдын хүлээлтэд нөлөөлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2016 оны сүүлийн дөрвөн сард сулрахад нөлөөлсөн. Гадаад валютын нөөц ийнхүү бага түвшинд хүрч, макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд бүгд эдийн засгийн хүндрэлийн нөхцөл байдлыг илтгэж байсан тул Монгол Улсын зээлжих зэрэглэл 2016 оны долдугаар сараас мөн оны арваннэгдүгээр сарын хооронд маш хурдацтай буурсан. Тухайлбал, Moody’s агентлаг зээлжих зэрэглэлийг хоёр шатлалаар бууруулж Саал ангилалд оруулсан. Ийнхүү зээлжих зэрэглэл буурснаар улсын эрсдэлийг өсгөж, гадаад зах зээл дээр гаргасан бондын үнэ хурдтай унаж, хүү (*Хөгжлийн банкны бондын үнэ унаж, хоёрдагч зах зээл дээрх хүү нь 38 хувьд хүрсэн*) нь өсөж байв. Харин ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т орох нь тодорхой болсны дараагаас хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, бондуудын хүү буурч, дахин санхүүжилтийн зардал бага байхад эерэгээр нөлөөлсөн билээ.

Монголбанк гадаад валютын нөөцийн дотоод гол эх үүсвэр болох үнэт металлын худалдан авалтыг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгө, ханшийн бодлогыг хослуулан үр дүнтэй хэрэгжүүлснээр гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийг сүүлийн хоёр жилд 3.5 дахин өсгөн 3.6 тэрбум ам.доллар (*импортын 8.5 сарын хэрэгцээг хангах түвшин*)-т хүргэн нэмэгдүүллээ. Монголбанк 2016 онд 18.6 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 22 тонн үнэт металл худалдан авч, энэ эх үүсвэрээс жил бүр 700-800 сая ам.долларыг бүрдүүллээ. ГВАН нэмэгдсэн нь үндэсний мөнгөн тэмдэгт-

төгрөгт итгэх итгэлийг сэргээх, улсын эрсдэлийг бууруулж, зээлжих зэрэглэл нэмэгдэхэд нөлөөлсөн үндсэн нэг хүчин зүйл байлаа. Тухайлбал, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2018 онд нэмэгдүүлж, Fitch болон S&P агентлагууд 2016 оны хүндрэлийн өмнөх түвшинд хүртэл сайжрууллаа. ГВАН-ийн хүрсэн түвшинг том дүнтэй интервенци хийх замаар эргүүлээд үрэн таран хийх нь эдийн засгийн дунд хугацааны төлөвт эргээд маш ноцтой эрсдэлийг бий болгоно гэж Монголбанк үзэж байна. Ялангуяа, гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр валютын ханш сулрах зах зээлийн нөхцөл бүрдсэн, сөрөг нөлөө нь харьцангуй удаан үргэлжлэхээр байгаа нөхцөлд интервенциэр ханшийг хүчээр барих оролдлого нь ГВАН-ийг шавхах л үр дагаварт хүргэхээр байна. Харин богино хугацааны хэт огцом хэлбэлзлийг бууруулах, валютын ханш суурь нөхцөлтэй нийцтэй түвшинд байлгах чиглэлд Монголбанк валютын зах дээрх оролцоогоо үргэлжлүүлэх нь зүйтэй байна.

Монголбанк эдийн засгийн сэргэлт, түүний хүртээмжтэй байдлыг хангахад бодит хувь нэмэр оруулж байна. Төв банкны үндсэн зорилт болох инфляцийг зорилтот түвшинд байлгах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих мөнгөний болон ханшийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж ирлээ. 2017-2018 онд эдийн засагт тулгарч байсан олон сорилтыг амжилттай даван туулж, эдийн засаг сэргэсэн, банк санхүүгийн салбарт реформ хийсэн шинэчлэлийн жилүүд болж өнгөрлөө. Тухайлбал, 2018 онд мөнгө, зээлийн зохистой өсөлтийг хангаснаар инфляци зорилтот түвшнээс бага буюу 7.3 хувьтай, харин эдийн засаг 6.9 хувиар өсөж, сэргэлт эрчимжиж байна. Эдийн засагт гарсан нааштай, эерэг нөхцөл байдалд тулгуурлан зээлийн хүүг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд банкнуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 оны эцэст 16.9 хувь болж, сүүлийн зургаан жилийн хамгийн бага түвшинд хүрлээ. Зээлийн хүүний бууралтын нөлөөгөөр банкнуудын бизнесийн зориулалттай, төгрөгөөр олгосон зээл өнгөрсөн онуудтай харьцуулахад өндөр хувиар өссөн нь бизнес эрхлэгчдийн дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байр, үйлдвэрлэл өсөхөд чухал түлхэц боллоо.

Өмнөх бодлогын алдаа, сургамжид үндэслэн зохистой засаглал, бодлогын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлснээр дунд болон урт хугацаанд тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх боломж нээгдэж, эдийн засгийн болон санхүүгийн хямралд өртөхгүй байх хөшүүрэг бүрдэнэ гэж үзсэн юм. Иймд 2017 оны эхээр Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлэхээр баталж, сүүлийн 2 жил гаруй хугацаанд амжилттай хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь: i) хууль, эрх зүйн орчинг сайжруулах; ii) засаглал, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх; iii) хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох; iv) дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх; v) хамтын ажиллагааг бэхжүүлэх гэсэн үндсэн таван чиглэлд тулгуурлаж байгаа болно.

Сүүлийн хоёр жил гаруй хугацаанд банк, санхүүгийн салбарт хууль эрхзүйн шинэчлэлийг амжилттай хийж, Төв банкны хараат бус байдлыг баталгаажууллаа. Банкны салбарын тулгуур хууль болох Төв банкны тухай, Банкны тухай, Банкны салбарын тогтвортой байдлын тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Төв банкны сайн засаглалын зарчмыг нэвтрүүлэн, бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг болж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болсон нь санхүүгийн салбарт болсон чухал үйл явдал байлаа [7]. Энэ нь мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, банкны салбарыг илүү эрүүл, чийрэг байлгах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, эдийн засгийг тогтворжуулах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монголбанк мөнгө, ханшийн бодлогоос гадна макро зохистой бодлого хэрэгжүүлдэг болж, бодлогын арга хэрэгслүүдээ өргөжүүлж, тэдгээрийг үр ашигтай ашиглаж байна. Үүний үр дүнд төв банкны үндсэн зорилт болох инфляцийг зорилтот түвшинд байлгах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлогыг амжилттай хэрэгжүүлж ирлээ.

Монголбанкны судалгаа, шинжилгээний ажилд өндөр ач холбогдол өгч гол ТинкТанк гэсэн байр сууриа бэхжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд улс орны хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлох том институци болгох стратегийн алсын хараатайгаар Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнг Монголбанкны дэргэд шинээр байгуулан ажиллуулж байна. Монголбанкны бодлого, судалгааны ажлыг бодлого боловсруулагчид, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн, судлаачид болон олон нийтэд хүргэж, тэдгээрийн санал, шүүмжийг авч тусгах зорилгоор мэргэжлийн болон нийтийн хэлэлцүүлэг, хурлыг богино давтамжтайгаар зохион байгуулж байна. Түүнчлэн “Монголбанкны мэдээлэл”, “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл, бусад судалгаа, шинжилгээний сэдэвчилсэн товхимол, ном зэргийг шинээр санаачлан гаргаж, нийтийн хүртээл болгоод байна.

5. Түүхэн сургамж, цаашид анхаарах асуудлууд

Түүхэн 95 жилийн хугацаанд монголчууд бид улс төр, нийгэм, эдийн засгийн цөөнгүй хүндрэлтэй нүүр тулж иржээ. Энэ хугацаанд бидэнд бие даасан эдийн засгийн бодлого боловсруулж ирсэн он жил цөөн байлаа. Тухайлбал, 1921 оны Ардын хувьсгалын дараах далан жилд Монгол Улс улс төр, эдийн засаг, худалдаа, цэрэг, геополитикийн бодлого дээр ЗХУ-ын тусламж дэмжлэгтэйгээр явж иржээ. Энэ түүхэн зурвас үед Монгол Улсын орчин үеийн эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын үндэс суурь тавигдаж, тусгаар тогтнолоо дэлхийн олон улс орноор хүлээн зөвшөөрүүлж, хүн амын тоогоо нэмэгдүүлсэн зэрэг олон ололт, амжилт бий.

1991 оны Ардчилсан хувьсгалын дараагаас манай орон ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжсэн эхний он жилүүдээс л олон улсын санхүүгийн байгууллагууд, доноруудын тусламж, дэмжлэгийг авч эхэлсэн. Сүүлийн 28 жилийн хугацаанд Монгол Улс ОУВС-гийн хөтөлбөрийг зургаан удаа авч, нийт 14 жилд нь тус сангийн хөтөлбөртэй явсаар өнөөдөртэй золголоо. Шилжилтийн

дараах он жилүүдэд буюу 1991-2000 онд гурван хөтөлбөр хэрэгжүүлсэн бол 2001-2010 онд хоёр хөтөлбөр, харин 2010 оноос хойш 2017 онд “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойших 28 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд тодорхой амжилтад хүрээд байна.

Гэвч улс орны макро эдийн засгийн болон хөгжлийн бодлого тогтворгүй явж ирлээ. Сүүлийн 28 жилийн хугацаанд Монгол Улс Ерөнхий сайд 15, Сангийн 15 сайд (*нэрийн давхардлыг хасвал тус бүр 14*), Монголбанкны 8 ерөнхийлөгчтэй байжээ. Сүүлийн таван жилээр үзэхэд, Ерөнхий сайд 4, Сангийн сайд 5-тай байжээ. Тогтвортой эдийн засгийн бодлого, төрийн бодлогын залгамж халаа манай оронд туйлын чухал байна.

Нийгэм, эдийн засгийн түүхэн үйл явдлаас урган гарч буй сургамжуудыг Монгол төрийн цаашдын бодлого, арга хэмжээнд анхаарч явах нь өнөө цагийн болон ирээдүй хойч үеийн бодлого боловсруулагч нарын эрхэм үүрэг билээ. Энэ агуулгын хүрээнд зарим сургамж, анхаарах асуудлыг нэгтгэн хүргэж байна:

Гадаадын капитал, хөрөнгө оруулалтын эсрэг үндсэрхэг үзэл үл гаргах. Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалт, түүнийг дагаж орж ирэх шинэ технологи, мэдлэгийн төлөөх тулааны талбар болсон энэ үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудаж, дэмжин ажиллах нь чухал юм. 1929 оны гадаадын капиталыг шахан зайлуулах үйл хэрэг нь Монгол Улсад хямрал дагуулсны дээр нэг зах зээлээс хэт хараат болгох үйл хэргийг хурдасгаж байжээ. Бид ардчилсан, зах зээлийн тогтолцоог бэхжүүлж, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг либералчилсан хэдий ч 90 жилийн дараа энэ алдааг давтах учиргүй. Харин ойлголцол, харилцан ашигтай хамтын ажиллагаа чухал юм. Монгол Улсад хэрэгжиж буй гадаадын хөрөнгө оруулалттай мега төсөл, төрийн хоорондын ойлголцол, үйл хөдлөлийг дэлхийн хөрөнгө оруулагчид бүгд анхааралтай ажиглаж байгаа. Хуримтлал багатай манай орны хувьд хөгжлийн цаашдын ирээдүйд гадны хөрөнгө оруулалт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Дотоодын санхүүгийн зах зээлийг хүчирхэг болгох. Санхүүгийн хүчтэй салбартай болох, санхүүгийн зах зээлийг зохистой түвшинд либералчлах, өрсөлдөөн бий болгох зорилтыг хангах нь бидний өмнө тулгарч буй сорилт юм. Гэхдээ түүх бидэнд үндэсний санхүүгийн тогтолцоогүй улс оронд гадны банкнууд зөвхөн ашиг хонжооны төлөө үйл хэрэг явуулж, ард түмэн өр, зээлд хэрхэн баригдаж, хүнд байдалд ордог сургамжийг өгч байна. ХХ зууны эхэн үеийн түүхээс харахад банкны лиценз гадны хүний гарт, эсвэл засгийн газарт нь шилжих, тухайн улсын ашиг сонирхлыг хэрэгжүүлэх хэрэгсэл болох боломжтой, үндэсний мөнгөн тэмдэг гүйлгээнд гаргах эрхийг төрдөө авч үлдэх нь ямар чухал болохыг сануулж байна. Түүнчлэн гадны зээл тусламжаар байгуулсан Үндэсний банк эхний он жилүүдэд Монголын үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх чиг үүрэг үүргээс илүүтэй зээлийн ихэнхийг зээл олгогч улсын худалдааны байгууллагад олгож, тухайн орноос эдийн засгийн хувьд хамааралтай байдлыг нэмэгдүүлэхэд үйлчилж байсан баримт бий. Иймд гадаадын банк дотоодын зах зээлд нэвтрэх

тохиолдолд түүний зорилго, стратеги, бизнес төлөвлөгөө, үүсэж болох эрсдэл, сэргийлэх арга хэмжээнд анхаарлаа хандуулах нь чухал байна. Нөгөө талдаа дотоодын дархлаатай, санхүүгийн хүчирхэг тогтолцоог бүрдүүлэх нь зөвхөн биднээс шалтгаалах билээ.

Ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, хүртээмжтэй өсөлтийг бий болгох. Сүүлийн жилүүдэд орлогын тэгш бус байдал нэмэгдэх хандлагатай байна. Бэлэн мөнгө тараах хөтөлбөрүүд нь эдийн засгийн олон асуудлыг дагуулсан хэдий ч ядуурлын түвшинг бууруулахад түр зуурын эерэг нөлөө үзүүлээ [10]. Манай эдийн засгийн хувьд эдийн засгийн хүндрэл (*жишээлбэл 2009 оны хүндрэл*), үнийн өсөлтийн дарамт нь орлого багатай хэсэгт илүү хүндээр тусдаг судалгааны үр дүн бий. Орлогын тэгш бус байдал нэмэгдэх нь ард олныг хэт үндсэрхэг үзэлд уриалан дуудах, иргэдийг хөрөнгө, үзэл бодлоор ялгаварлан гадуурхаж, дотоодын зөрчилдөөнд дуудсан 1930-аад оны хямралт байдалд уруу татах хөрсийг бүрдүүлж, эмзэг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлийг хуримтлуулна. Иймд төрийн бодлогын ил тод байдал, тайлбар үндэслэлийг нийтэд хүргэх нь чухал юм. Мэдээж ядуурлын түвшинг үргэлжлүүлэн бууруулах, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бүрдүүлэх нь тулгамдаж буй асуудал юм. Хүртээмжтэй эдийн засгийн өсөлт нь дан ганц эдийн засгийн хэмжээг тэлэх бус мөн нийгмийн эмзэг бүлгийн амьжиргааг сайжруулах асуудал юм. Эдийн засгийн өсөлтөөс бүгд тэгш хүртэх боломжоор хангагдах, өсөлтөд бүгд оролцдог байх (*ялангуяа ажил эрхэлж буй ядуу болон ажилгүй иргэдийн хувьд*) нь хүртээмжтэй өсөлтийн суурь билээ. Ядуурал, орлогын тэгш бус байдлын бууруулах чиглэлд төрийн оролцоо яригдах үед орлогын дахин хуваарилалт гарч ирнэ. Төр харьцангуй өндөр орлоготой хэсгээс татвар авч орлого багатай зорилтот бүлэгт зайлшгүй шаардлагатай байгаа нийгмийн тусламж, үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэх ёстой. Үүний зэрэгцээ өрхийн аж ахуйн өрийн дарамт сүүлийн жилүүдэд нэмэгдэж, өрхийн санхүү болон иргэдийн зээлийн чанарын макро шокуудаас хамаарах эмзэг байдал илт нэмэгдээд байна [12]. Иймд өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого нь өрхийн аж ахуйн тогтвортой байдал, улмаар санхүүгийн салбарт эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг сахин хамгаалах. Түүхэн хугацаанд төв банкнууд улс орны бүтээн байгуулалт, эдийн засгийн салбарын хөгжилд санхүүжилт олгох хэлбэрээр үүрэг гүйцэтгэж байлаа. Монголбанк ч 1924-1996 оны хороонд энэ зарчмаар ажиллаж иржээ. Дэлхийн улс орны шилдэг туршлагыг иш үндэс болгон төв банк нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, тэр дундаа үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангахын тулд үйл ажиллагааны хувьд бие даасан байх ёстой гэсэн зарчмыг 1996 оны Төв банк (Монголбанк)-ны тухай хууль батлагдсанаар эрх зүйн үндэс анх нь тавигдсан билээ. Үүнээс хойш ил, далд хэлбэрээр Монголбанкны бие даасан, хараат бус байдалд улс төрийн нөлөө байсаар ирэв. Үүний хамгийн сүүлийн том жишээ нь төв банкнаас 2012-2016 онд хэрэгжүүлсэн 7.2 их наяд төгрөгийн төсвийн шинж чанартай арга хэмжээ юм. Үүний үр дагаварт гадаад валютын цэвэр албан нөөц ОУВС-гийн тодорхойлолтоор -2.75 тэрбум ам.долларт хүрч,

Монголбанкны алдагдал -3.0 их наяд төгрөгт хүрэв. Энэ үйл явдлыг бид дахин давтах ёсгүй юм. Монголбанкаар дахин төсвийн шинж үйл ажиллагааг санхүүжүүлэх зөвлөмж, үүрэг даалгавар дахин хэзээ ч давтагдаж болохгүй. Энэ тохиолдолд Монголын эдийн засгийн дархлаа ноцтой суларч, эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой хохирол учирна. Монголбанк хууль заасан үндсэн зорилт (*үндэсний мөнгөн тэмдэг-төгрөгийн тогтвортой байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах*)-оо хангахад л мөнгөний бодлогыг чиглүүлж, түүний хэрэгжилтийн өмнө хариуцлагаа хүлээх учиртай. Ардчилсан, зах зээлийн нийгэм шилжсэн 29 жилийн хугацаанд бид олсон ололтоо баталгаажуулах, алдсан алдаанаас сургамж авсан зүйлсээ хууль, эрх зүйн бичиг баримтад тусгах ажлыг хийж, олон улсын сайн туршлагуудыг тухай бүр нь шингээж ирсэн. Харин бидний хувьд одоо байгаа хууль, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангахад онцгой анхаарах шаардлагатай байна. Түүхээс харахад, бид хуулийг дагаж мөрдөхөөс илүүтэй, түүнийг тойрох, хуулийн өөрчлөх байдлаар асуудал хандаж ирсэн гашуун сургамж байна.

Банкны салбарын тогтвортой байдалд онцгой анхаарах. Бид 1994 оноос хойш банкны дампуурал, хүндрэлтэй цөөнгүй нүүр тулж ирлээ. Банкны дампуурал нь нэг талаас хадгаламж эзэмшигчдийн хуримтал эрсдэх эсвэл төрөөс дахин хөрөнгөжүүлэх тохиолдолд татвар төлөгчдийн мөнгөнөөс тухайн зориултад ашиглагдахад хүргэдэг. Банкны дампуурал нь иргэдийн банкинд итгэх итгэлийг алдагдуулж, банкнаас хадгаламжаа эргүүлэн татах үзэгдэлд амархан өртөмтгий болгож, санхүүгийн эс зуучлал бий болдог болохыг 1996-1998 оны банкны дампуурлын дараа бид харсан. Нөгөө талд манай орны хувьд банкны салбарын мөчлөг дагах байдал өндөр явж ирлээ. Эдийн засгийн өрнөлийн үед банкнуудын зээл маш өндөр хувиар өсдөг. Банкнуудын депозит өсөж, улмаар хүүний зардал нэмэгдэж байгаа тул орлогоо нэмэгдүүлэх, эдийн засгийн өрнөлийн үед зээлийн эрсдэл ч бага харагддаг тул зээлээ өсгөх байдал харагддаг. Гэхдээ зээлийн хэт өндөр өсөлт нь эдийн засгийн дараагийн хүндрэлийн суурийг бэлддэг. Зээл ихээр авсан бизнесүүд гадаад сөрөг шок эхлэх даруйд үйл ажиллагаа нь доголдож, улмаар зээлийн төлбөрийн хүндрэлд ордог. Эдийн засаг хүндрэхийн хэрээр энэ байдал улам даамжирсаар чанаргүй зээлийн хэмжээ өсдөг. Нэгэнт чанаргүй зээл, зээлийн алдагдлын сан өсөж байгааг харсан банк макро эдийн засгийн ийм орчинд шинээр зээл гаргахгүй, улмаар зээлийн тасалдал үүсдэг. Ингээд бодит сектор, банкны салбар хамтдаа харилцан нэгэндээ сөргөөр нөлөөлсөөр эдийн засгийн хүндрэлд ордог. Энэ мөчлөгийг бид олон удаа харж байна. Өөрөөр хэлбэл, эрсдэл даах чадваргүй болж байгаа банкны салбар санхүүгийн зуучлалын үүргээ биелүүлж чадахгүйд хүрдэг. Иймд эдийн засгийн өсөлтийг дэмжихүйц санхүүгийн зуучлалтай байхын тулд хүчирхэг, эрүүл банкны тогтолцоотой байх шаардлагатай болж байна. Үүний тулд банкнуудын мөчлөг дагах байдлыг бууруулсан, банкны салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд албадагын арга хэмжээ авах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх нь чухал байна [13].

Гадаад өрийн түвшин өндөрт хүрсэн энэ үед макро эдийн засгийн болон санхүүгийн зохистой бодлого хэрэгжүүлэх нь чухал байна. Монгол Улсын гадаад өр 2018 оны эцсийн байдлаар 28.7 тэрбум ам.доллар, үүнээс Засгийн газар болон төв банкны гадаад өр нийлээд 9.2 тэрбум ам.долларт хүрээд байна. Ирэх таван жилд нийт гадаад өрийн 40 гаруй хувьтай тэнцэх хэмжээний эргэн төлөлт (хүүний төлбөр оруулснаар) хийгдэхээр хүлээгдэж байна. Ийм орчинд одоо хэрэгжиж буй ОУВС-гийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь манай эдийн засгийн хэтийн төлөвт стратегийн чухал ач холбогдолтой. Тэр дундаа, Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлыг дунд хугацаанд үргэлжлүүлэн хангахад ОУВС болон бусад доноруудын тусламж дэмжлэг цаашид ч онцгой шаардлагатай юм. Монгол Улс 2020-2024 онд нийт 12.2 тэрбум ам.доллар, үүнээс Засгийн газар, төв банкны 7.1 тэрбум ам.долларын гадаад өрийг төлөхөөр хүлээгдэж байна. Одоогийн гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцлийн нөхцөл байдлаас харахад энэхүү өрийн дийлэнхийг дахин санхүүжүүлэх хэрэгцээ, шаардлага өндөр хэвээр байна. Дахин санхүүжилтийн хүү, нөхцөлийг таатай байлгах, улмаар гадаад өрийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэх хангахад макро эдийн засгийн харилцан хосолсон, тогтвортой өсөлтөд чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, ОУВС болон бусад донортой үргэлжлүүлэн хамтран ажиллах нь зайлшгүй болж байна. Үүний тул ОУВС болон бусад донор байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг бүрэн биелүүлж ажиллах нь Монгол Улсын хөгжлийн цаашдын төлөвт нэн чухал боллоо. Нэг талаас биднийг хөрөнгө оруулагчид, зэрэглэл тогтоогч агентлагууд анхааралтай ажиглаж байна. Нөгөө талаас энэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, эдийн засгийн бат суурийг бүрдүүлэхгүй тохиолдолд манай эдийн засаг илүү хүнд байдалтай нүүр тулна. Балансын аргачлал (BSA)-д суурилсан Монголын эдийн засгийн эмзэг байдлын шинжилгээ нь цаашид эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг нэгэн зэрэг хангах¹¹ (эдийн засгийн тогтвортой байдлыг хангах)-д гадаадын хөнгөлөлттэй санхүүжилт зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна [15].

Сүүлийн 28 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн макро бодлогоос гарч буй бусад сургамж, зөвлөмж дараах байдалтай байхаар байна. Үүнд:

- **Эдийн засгийн өрнөл, сэргэлтийн үед нөөц хөрөнгө бүрдүүлэх.** Мөчлөгийн далайцыг бууруулахын тулд өрнөлийн үед нөөц хөрөнгө бүрдүүлж, хүндрэлийн үед түүнийг ашигладаг олон улсын туршлагыг амжилттай хэрэгжүүлэх шаардлага хэвээр байна. Гадаад валютын орох

¹¹ Засгийн газар, хувийн хэвшлийн позици сөрөг өндөр түвшинд байгаа үед гадаад сөрөг шокийн нөлөөгөөр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах нь гадаад өрийг нэмэгдүүлж, дарамтыг улам өсгөж, дотоодын санхүүгийн салбар хүнд байдалд орж, ханшийн болон банкны хямралын нөхцөл байдал үүснэ. Үүнээс зайлсхийх зорилгоор бодлогын хүүг өсгөх нь дотоод өртэй иргэд, аж ахуйн нэгжид дарамт болж, дотоод эрэлт хумигдах тул эдийн засаг мөн хүндрэлд орно. Иймд энэ хоёр асуудлаас нэгэн зэрэг зайлсхийх боломж нь гадаадын хөнгөлөлттэй санхүүжилтийг олон улсын санхүүгийн байгууллага, донороос авах явдал юм. Энэ нөхцөл байдал үүссэн тул 2017 онд ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт орохоос өөр сонголт байгаагүй гэж хэлж болно.

урсгал өндөр үед гадаад валютын нөөцийг хангалттай хуримтлалгүй, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг чангаруулж, дараагийн ханшийн огцом сулралт бий болох нөхцөлийг бүрдүүлдэг алдааг давтаж болохгүй.

- **Төсвийн сахилга батыг чанд мөрдөх.** Төсвийн тэлэлт нь эдийн засгийн хэт халалт (*өндөр өсөлт, өндөр инфляци, ханшийн сулрах дарамт, зээлийн өндөр өсөлт, өндөр хүү*)-ыг бий болгож, дараагийн хүндрэлийн суурийг бэлддэг. Хөөс хагарч, хүндрэл бий болох үед төсөв нь дагаад хүндрэдэг тул эдийн засгийг эргэн сэргээх нөөцгүй болдог байдал цөөнгүй давтагдлаа. Харин эдийн засгийн өрнөлийг дагасан төсвийн огцом тэлэлт нь хүндрэл, хямрал бүрийн эхлэлийн шалтгаан болно. Төсвийн давамгайлал нь мөнгөний бодлогыг үр нөлөөгүй болгож, төсвийн зардал тэлэх нь хувийн хэвшлийн зээлийг шахан гаргахад хүргийг 2015-2016 оны эдийн засгийн хүндрэлээс харж болно.
- **Богино хугацааны хэрэглээнээс илүүтэй урт хугацааны хөгжилд анхаарах.** Манай орны байгалийн баялгаас орлого бүрдүүлэх татвар, хураамжийн орчин нь бусад орны адил тогтвортой бус, орж ирэх орлого нь бага, хэлбэлзэл өндөртэй байна. Үр дагавар нь уул уурхайн салбар сэргэж, үйлдвэрлэл нэмэгдсэнээс ДНБ-ий өсөлт өндөр гардаг хэдий ч үндэсний нийт орлого (ҮНО) зэрэг иргэдийн амьжиргааг илүү хэмжих үзүүлэлт дээр бодит эерэг нөлөө сайн гарахгүй байна. Нөгөө талдаа байгалийн баялгаас орж ирсэн орлогын дийлэнхийг нэн шаардлагатай дэд бүтэц, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхэд шаардлагатай үр ашиг өндөртэй төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах буюу урт хугацааны эдийн засгийн хөгжилд чиглэсэн дэд бүтцэд зарцуулах ёстой. Гэтэл зөвхөн одоогийн хэрэглээг дэмжсэн арга хэмжээнд зориулаад дуусгадаг “муу” жишиг тогтоод байна.
- **Эдийн засгийг төрөлжүүлэх.** Манай орны эдийн засгийн гадаад шоконд өртөх эмзэг байдал өндөр хэвээр байна. Монгол Улс түүхий эд экспортлогч орон тул “төрөлхийн” эмзэг байдалтай. Ган-Очир, Даваажаргал [14] нарын судалгааны үр дүнгээс харахад, гадаад шок бодит ДНБ-ий хэлбэлзлийн 40-50 орчим хувийг, хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийн хэлбэлзлийн 40-55 орчим хувийг бий болгож байна. Энэхүү гадаад шоконд өртөх эмзэг байдлыг бууруулж, эдийн засгийн дархлааг бий болгохын тулд хуримтлалын сан байгуулах, хөвөгч валютын ханштай байх, оновчтой макро бодлого (*макро зохистой бодлогыг оруулаад*) хэрэгжүүлэх сорилт тулгарч байна [11]. Харин дунд, урт хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэхгүйгээр энэхүү глобал мөчлөгт өртөх байдлаас салж чадахгүй. Байгалийн баялгийн салбар, түүнээс орж ирэх орлогод түшиглэн эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай байна. Эдийн засгийн төрөлжилтийг бий болгох

болгохын тулд нөөцийн салбартай уялдаатай бусад салбаруудыг дэмжих асуудал чухал байна. Монголын эдийн засгийн эмзэг байдлыг Балансын хандлага (*Balance Sheet Approach*)-аар шинжлэхэд эдийн засгийн гадаад сектор (*түүхий эдийн үнэ, валютын ханшийн сулралт*)-оос хамаарах эмзэг байдал өндөр хэвээр байна [15].

- **Зах зээл дэх төрийн хэт оролцоог хязгаарлах.** Онолын хувьд хаана орхигдсон зах зээл (*market failure*) байна, тэнд төр орж тухайн орхигдсон бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх ёстой. Харин хувийн сектор хэвийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлд төр давхар оролцох шаардлагагүй. Иймд Засгийн газраас аль болох зах зээлд шууд оролцохоос илүүтэй зах зээл үр ашигтай ажиллах¹² орчинг сайжруулахад илүү анхаарах шаардлагатай [8]. Түүнчлэн эдийн засаг дахь Засгийн газрын зардлын хэмжээг боломжит бага түвшинд байлгаж, хувийн секторын өсөн хөгжих боломжийг олгох явдал чухал байна. Төрөөс дотоодын зарим салбар, компаниудад дэмжлэг (*татаас олгох, эсвэл тарифын хөнгөлөлт эдлүүлэх*) үзүүлж ирсэн хэдий ч бодит үр дүн туйлын хангалтгүй байна. Ялангуяа Засгийн газар аль салбарыг хэрхэн сонгож, тэдгээр салбарын ирээдүйн чиг хандлагыг хэрхэн үнэлсний үндсэн дээр тусламж үзүүлсэн нь эргэлзээ, хардлагыг дагуулдаг. Засгийн газраас салбаруудыг тэгш бус ялгаварлан дэмжлэг үзүүлэх нь өөрөө үр ашиггүй бөгөөд сонирхлын бүлгүүдийн ашиг сонирхлыг нэмэгдүүлж, дараагийн гажуудлыг бий болгодог [1].
- **Засаглал, институцийг бэхжүүлэх.** Засаглалыг сайжруулах нь хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлд хуулийг боловсронгуй болгох, хуулийг хэрэгжүүлэх явдал юм. Авилгал нь зөвхөн өнөөдрийн асуудал бус ирээдүйд бидний хөгжих боломжийг давхар хязгаарлаж байгааг анхаарах шаардлагатай. Үндэсний эрх ашгийн төлөө шийдвэр гаргадаг удирдагч, төрийн албан хаагчтай болохгүй тохиолдолд “байгалийн баялгийн хараал” биднийг хүлээж байна. Түүнчлэн төрийн бодлогын шийдвэр удирдлагад байгаа тухайн нэг хувь хүнээс л хамаардаг бус, эрх, үүрэг, хяналт болон хариуцлага нь тодорхой эрх зүйн бичиг баримтын хүрээнд тодорхой байх нь чухал юм. Энэ хүрээнд төрийн байгууллага бүрийн засаглал, институцийг бэхжүүлэх асуудал чухал байна [4].
- **Логистикийг хөгжүүлэх.** Манай орны дундаж өрхийн хэрэглээний сагсанд хүнсний бүтээгдэхүүний болон импортын барааны эзлэх жин бусад оронтой харьцуулахад өндөр байдаг. Малчны хот, эсвэл фермерээс жижиглэнгийн худалдаанд ирэх хүртэлх хэт олон шат дамжлага нь өртгийн өсөлтийг бий болгохын зэрэгцээ эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэж, хадгалж байгаа эсэх талаарх

¹² Эдийн засгийн шинжлэх ухаанд зах зээлийн үр ашиг нь эдийн засаг дахь нөөц үнийн механизмаар дамжин оновчтой байршсанаар бий болно гэж үздэг.

эргэлзээг бий болгож байна. Үүний зэрэгцээ нийлүүлэлт өндөр байх үед нөөцөлж, нийлүүлэлт хомсдох үед нийлүүлдэг тогтолцоог бүрдүүлэх нь чухал байна. Үүнтэй адилаар олон улсын логистикийн сүлжээнд мөн анхаарал хандуулах шаардлагатай байна. Импортын барааны өртгийн 25 орчим хувь нь ложистиктэй холбоотой гэсэн тооцоо бий. Энэхүү өртгийг бууруулж, шуурхай тээвэрлэх асуудлыг шийдвэрлэснээр ижил чанартай бараа, бүтээгдэхүүнийг хямд байгаа газраас авах, өөрийн экспортыг гадаад руу шуурхай, өртөг багатай гаргах давуу тал бүрдэнэ.

Ном зүй:

- [1] П.Авралт-Од, Д.Ган-Очир, Б.Даваадалай, Б.Дуламзаяа, Б.Цэнд-Аюуш, Б.Ундрал 2012, ‘Монголын эдийн засаг дахь Голланд өвчний шинж тэмдэг’, Монголбанкны судалгааны ажлын товхимол-8.
- [2] Д.Ариунаа, Х.Баярмаа, Ч.Болдбаатар, В.Уянга 2018, *Монголбанк түүхийн альманах*, ISBN: 978-99975-51-75-8, НЕПКО ХХК.
- [3] О.Батсайхан болон З.Лонжид 2019, *Монголбанк 95: Түүх ба баримт*, ISBN: 978-99978-66-75-2, Мөнхийн үсэг ХХК.
- [4] Н.Баяртсайхан болон Д.Ган-Очир 2017, ‘Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох бодлогын асуудалд’, *Мөнгө, Санхүү, Баялаг*, № 2.
- [5] Н.Баяртсайхан 2018, *Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөө дээдэлье*, ISBN 978-99978-2-058-7, Адмон принт ХХК.
- [6] Н.Баяртсайхан 2019, ‘Мөнгөний бодлого’, Бүлэг 2.2, *Монгол төрийн эдийн засгийн бодлого: сорилт, сургамж, асуудал 1911-2018* (редактор Л.Ариунаа), ISBN: 978-99978-68-83-1, Мөнхийн үсэг ХХК.
- [7] Н.Баяртсайхан 2019, ‘Өрийн удирдлага: Их өр үүсэн түүхэн, бүтээн байгуулалт, төлбөр’, Бүлэг 2.5, *Монгол төрийн эдийн засгийн бодлого: сорилт, сургамж, асуудал 1911-2018* (редактор Л.Ариунаа), ISBN: 978-99978-68-83-1, Мөнхийн үсэг ХХК.
- [8] Д.Ган-Очир 2012, ‘Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: инфляци, эдийн засгийн өсөлтийн хөтөч үзүүлэлтийг тодорхойлох нь’, Монголбанкны судалгааны ажлын товхимол-7.
- [9] Gan-Ochir, D and Kalirajan, K 2016, ‘Interest rate pass-through in Mongolia’, *The Developing Economies*, vol 54, no. 4, pp. 271–291.
- [10] Gan-Ochir, D and Ariun-Erdene, B 2017, ‘Implications of economic growth, poverty and inequality in Mongolia over the period of 2008-2012’, *The Northeast Asian Economic Review*, vol. 5, no. 2, pp. 15-29.
- [11] Gan-Ochir, D 2018, ‘The effect of real exchange rate on trade balance in a resource-rich economy: The case of Mongolia’, *Foreign Trade Review*, vol. 53, no.4, pp. 1-14.
- [12] Gan-Ochir, D and Ariun-Erdene, B 2017, ‘Stress testing the household sector in Mongolia’, *The Asia-Pacific Development Journal*, vol. 24, no. 2, pp. 23-52.
- [13] Gan-Ochir, D and Undral, B 2018, ‘Monetary and macroprudential policy in a commodity exporting economy: A structural model analysis’, *Central Bank Review*, vol. 18, no.3, pp. 1-22.
- [14] Gan-Ochir, D and Davaajargal, L 2019, ‘External Shocks and Business Cycle Fluctuations in Mongolia: Evidence from a Large Bayesian VAR’, *International Economic Journal*, vol. 33, no. 1, pp. 42-64.

- [15] Д.Ган-Очир, С.Номин, Г.Мөнхбаяр, Б.Анхцэцэг 2019, ‘Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: Балансын аргачлал (BSA)’, хэвлэгдээгүй бичвэр, Монголбанк.
URL: https://www.mongolbank.mn/documents/press_conference/20190312_01.pdf
- [16] Hart, J 1967 ‘20th year of economic planning’, *Asian Survey*, vol. 8, no. 1, pp. 21-28.
- [17] Ирвин, Н 2017, ‘Алхимичид- Төв банкны гурван тэргүүн ба түймэрт автсан дэлхий’, ISBN: 978-99978-5-585-0, NNC Publishing, Мөнхийн Үсэг ХХК.
- [18] Kaser, M 1982, ‘The industrial revolution in Mongolia’, *The World Today*, vol. 38, no. 1, pp. 12-17.
- [19] KPMG 2018, ‘Монголбанк: Төсвийн шинжтэй хөтөлбөр арга хэмжээний хөндлөнгийн тусгай үнэлгээ’, Кэй Пи Эм Жи Аудит ХХК.
URL: https://www.mongolbank.mn/documents/MN_QFPA%20Review%20BOM%20Final%20report_v2.0.pdf
- [20] Laevan, L and Valencia, F 2013, ‘Systemic banking crisis database’, *IMF Economic Review*, vol. 61, no. 2, pp. 225-270.
- [21] Монголбанк 2014, ‘Банк 90: Банкны 2 шатлалт тогтолцооны үүсэл, хөгжил 1991-2014’, Интерпресс ХХК.
- [22] Д.Моломжамц (1993), ‘Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийн явц, цаашдын зорилтын мэдээлэл’, УИХ-д тавьсан илтгэл, *Монголбанк 95: Түүх ба баримт* (О.Батсайхан болон З.Лонжид) номонд орсноор авч ашиглав.
- [23] Д.Моломжамц (1994а), ‘Монголын банк 70 жилд’, Монгол Улсад банк байгуулагдсаны 70 жилийн ойн баярын хурал дээр тавьсан илтгэл, *Монголбанк 95: Түүх ба баримт* (О.Батсайхан болон З.Лонжид) номонд орсноор авч ашиглав.
- [24] Д.Моломжамц (1994b), ‘Мөнгө зээлийн бодлогын асуудал’, УИХ-аас зохион байгуулсан онол, практикийн бага хуралд тавьсан илтгэл. *Монголбанк 95: Түүх ба баримт* (О.Батсайхан болон З.Лонжид) номонд орсноор авч ашиглав.
- [25] Н.Янзан (1983), ‘БНМАУ-д үндэсний банк байгуулагдсаны болон мөнгө, зээлийн систем үүсэж хөгжсөний 60 жилийн ойг угтаж Улсын банкны ерөнхий хороо, Төв аймгийн намын хорооноос Зуун мод хотод зохион байгуулсан “Үндэсний банк, мөнгө зээлийн системийн үүсэл, хөгжилт, зорилт, банкны болон харилцагч байгууллагын үүрэг хариуцлага” сэдвээр хийх онол, практикийн бага хуралд тавих илтгэл’, *Монголбанк 95: Түүх ба баримт* (О.Батсайхан болон З.Лонжид) номонд орсноор авч ашиглав.